



ДОТООД  
ХЭРГИЙН  
ИХ СУРГУУЛЬ

# ЦАГДААГИЙН АЛБАНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ ХҮНИЙ ЭРХИЙН ХЭМ ХЭМЖЭЭНД НИЙЦЭЖ БУЙ ЭСЭХ

Улаанбаатар хот  
2020 он

ННА 67.3  
ДАА 340.009  
Э-739

**ЦАГДААГИЙН АЛБАНЫ  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ ХҮНИЙ ЭРХИЙН  
ХЭМ ХЭМЖЭЭНД НИЙЦЭЖ БУЙ ЭСЭХ**

Судлаачид: Д.ЭРДЭНЭБААТАР, Доктор (Ph.D)  
Ю.БАДАМХАНД, Доктор (Ph.D), Дэд профессор  
Д.БУЛГАН, Доктор (Ph.D)

© Нээлттэй Нийгэм Форум, 2020 он  
Уг тайланг ашиглахдаа эх сурвалжийг дурдана уу.

Хаяг: Жамьяан гүний гудамж  
Сүхбаатар дүүрэг  
Улаанбаатар 14240  
Утас: 976-11-313207  
факс: 976-11-324857  
Веб: <http://www.forum.mn>  
И-мэйл: [osf@forum.mn](mailto:osf@forum.mn)

ISBN 978-9919-9574-7-6

## АГУУЛГА

ОРШИЛ .....	4
СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД .....	6
СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, АРГАЧЛАЛ .....	6
СУДАЛГААНЫ ДҮН .....	7
Нэг. ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ .....	7
Хоёр. ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ БА ХҮНИЙ ЭРХ .....	13
Гурав. ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ ХҮНИЙ ЭРХЭД НИЙЦСЭН ЭСЭХ .....	17
3.1. Хүний эрхийн хэм хэмжээ, хууль тогтоомжид нийцсэн журмууд .....	26
3.2. Хүний эрхийн хэм хэмжээ, хууль тогтоомжтой зөрчилдсөн журмууд .....	28
3.3. Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжид нийцээгүй, эсхүл тодорхой үйл ажиллагааг нарийвчлан тогтоох шаардлагатай журмууд .....	48
ДҮГНЭЛТ .....	70
САНАЛ, ЗӨВЛӨМЖ .....	73

## ОРШИЛ

Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэж заасан. Цагдаагийн албаны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт<sup>1</sup> цагдаагийн алба (алба хаагч) нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хуульд зааснаас гадна хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, ил тод, нээлттэй байх, нууцыг чанд хадгалах, олон нийтийн итгэл хүлээж, дэмжлэг авах, үйл ажиллагаа нь тасралтгүй байх, улс төрөөс ангид байх, нэгдмэл төвлөрсөн удирдлагатай байх зарчмыг баримтална гэж тусгайлан заасан.

Үндсэн хуульд заасан төрийн үйл ажиллагааны зарчмыг цагдаагийн алба бүхий л үйл ажиллагаандаа, түүн дотор дотоод дүрэм журмаа боловсруулахдаа баримтлах ёстой. Цагдаагийн төв байгууллагын даргын тушаалаар гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр дүрэм, журам, заавруудыг баталж, мөрдүүлсээр ирсэн бөгөөд эдгээр дүрэм, журмыг системчилж, кодчилох ажлыг 2008 оноос эхлүүлсэн байна. Энэ ажлын үр дүнд цагдаагийн алба хаагчийн өдөр тутмын ажиллагааг зохицуулж буй бүх дүрэм, журмыг нэгтгэн “Монгол Улсын Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам” хэмээх эмхэтгэлийг хэвлэж алба хаагч бүрт гардуулж өгсөн билээ. Ингэснээр цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа нэг мөр хэрэгжихэд алба хаагчдад тун чухал гарын авлага болж байгаа. Тус эмхэтгэлийг 2 жил тутамд шинэчилж байхаар зохицуулсан нь хууль дээдлэх зарчмыг мөрдөж ажиллах, алба хаагч бүрт өөрчлөгдөж буй дүрэм, журмыг цаг алдалгүй хүргэхэд тун чухал ач холбогдолтой хэдий ч энэ хугацааг одоогоор мөрдөж эхлээгүй байна. Анх системчлэх ажил эхэлснээс хойш тус эмхэтгэл 3 удаа хэвлэгджээ.

Цагдаагийн байгууллага нийт дүрэм журмаа системчлэн, кодлоод зогсохгүй шинэчлэн өөрчлөгдөж буй хууль тогтоомж, хүний эрхийн хэм хэмжээнд нийцүүлэх, гадаад улсын туршлагыг нэвтрүүлэхийг зорьж

<sup>1</sup> Цагдаагийн албаны тухай хууль. Төрийн мэдээлэл. 2017. №8.

ирсэн. Энэ хүрээнд Цагдаагийн дарга нарын олон улсын холбооноос гаргасан 123 загвар кодоос 51-ийг буюу нийт 887 хуудас материалыг монгол хэл рүү хөрвүүлсэн бөгөөд энэ ажлыг 2013 онд Хууль зүйн яам, Нээлттэй Нийгэм Форумын хооронд байгуулсан санамж бичгийн хүрээнд хэрэгжүүлсэн юм. Цагдаагийн албаны хуулийн шинэчилсэн найруулга 2014 оны 1-р сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн, мөн олон улсын загвар кодыг монгол хэл рүү хөрвүүлснийг тохиолдуулан “Монгол Улсын Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам”-ыг шинэчлэх ажлыг ЦЕГ 2015 онд эхлүүлсэн.

Ийнхүү цагдаагийн албаны дотоод дүрэм журмыг шинэчлэх, системчлэх, нэгтгэн эмхэтгэх ажил хийгдэж эхэлснээс хойш 10 орчим жил өнгөрч, энэ хугацаанд Цагдаагийн албаны тухай хууль хоёр удаа шинэчлэн найруулагдаж, мөн шинэ эрүүгийн хууль тогтоомж мөрдөгдөж эхэлсэн билээ. Үүнтэй холбогдуулан тус дүрэм, журам нь хүний эрхийн зарчим, стандартад хэрхэн нийцэж буй эсэхийг энэхүү судалгааны хүрээнд авч үзэж, дүгнэлт гаргахыг зорилоо.

## **СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД**

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам (ЦБҮАЖ) хүний эрхийн стандарт, хууль тогтоомжид нийцсэн байдалд дүн шинжилгээ хийж, цаашид боловсронгуй болгох санал, зөвлөмж боловсруулахад энэ судалгааны ажил чиглэсэн. Энэхүү зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлж ажиллалаа. Үүнд:

1. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмууд хүний эрхэд нийцсэн байдлыг тодорхойлох шалгуур үзүүлэлтийг боловсруулж, тодорхой шалгуураар сонгож авсан журмууд (132)-ын хүний эрхэд нийцсэн байдлыг судлах;
2. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэхэд дүн шинжилгээ хийх;
3. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмыг боловсронгуй болгох санал, зөвлөмж боловсруулах.

## **СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, АРГАЧЛАЛ**

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам (БҮАЖ) нь хүний эрхэд нийцсэн талаар дүн шинжилгээ хийхдээ судалгааны ажилд өргөн хэрэглэгддэг тоон болон чанарын судалгааны загвар, арга зүйг хослуулж онол, эрх зүйн зохицуулалт, гадаад, дотоодын судлаачдын бүтээл, судалгааг харьцуулан үзэхийн тулд харьцуулалтын арга, хууль тогтоомж, үйл ажиллагааны журмуудад тодорхой шалгуур, үзүүлэлт тогтооход түүвэрлэн судлах, сонгосон баримт бичигт дүн шинжилгээ хийх, өөрсдийн хийсэн дүн шинжилгээг магадлан шалгахын тулд экспертүүдтэй болон төрөл бүрийн түвшний алба хаагч нартай уулзаж ярилцах фокус ярилцлагын аргыг тус тус ашиглахын зэрэгцээ мэдээлэл боловсруулах, задлан шинжлэх аргад мөн тулгуурласан болно.

Баримт бичгийн шинжилгээнд НҮБ-ын “Human rights indicators”-ын хүрээнд аргачлал боловсруулж, холбогдох тайлан мэдээ, энэ чиглэлээр авч хэрэгжүүлж ирсэн арга хэмжээ, тушаал, шийдвэртэй танилцан

ЦБҮАЖ нь хүний эрхийн үзүүлэлтэд хэрхэн нийцэж байгааг судаллаа. Хүний эрхийн үзүүлэлтүүд (structural indicators, process indicators, outcome indicators)-д цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа нь хэрхэн нийцэж байгааг олон улсын болон цагдаагийн байгууллагын холбогдох баримт бичиг, судлаачдын бүтээлтэй харьцуулан судалж шалгуур үзүүлэлтийг боловсруулан дүн шинжилгээ хийлээ. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмуудаас хүний эрхтэй дам болон шууд байдлаар уялдаж буй журмуудыг түүврийн аргаар сонгон авч Хүний эрхийн түгээмэл тунхаглал болон Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний эрхүүдтэй харьцуулан судаллаа.

## СУДАЛГААНЫ ДҮН

### Нэг. ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

Монгол Улсын Үндсэн хуулийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “...үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн” гэж заагаад, 38 дугаар зүйлд “хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийгмийн хэв журмыг бэхжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх”<sup>2</sup> үүргийг Засгийн газарт хүлээлгэсэн. Монгол Улсын Үндсэн хууль, цагдаагийн байгууллагад үүрэг болгосон бусад хууль, олон улсын гэрээ, конвенц, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний актууд болон тэдгээрт нийцүүлэн цагдаагийн төв байгууллагаас гаргасан үйл ажиллагааны журмууд нэгдэж цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлдэг.

Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд цагдаагийн байгууллагын хууль тогтоомжийг Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн шинэчлэх ажлыг эхлүүлж, “Цагдаагийн байгууллагын тухай” (1993), “Цагдаагийн албаны тухай” (2013, 2017) хуулиуд батлагдсанаар цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны үндэс бүрдэж, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журмыг сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлд бодит ахиц гарсаар байна.

<sup>2</sup> Монгол Улсын Үндсэн хууль. Төрийн мэдээлэл. УБ. 1992. № 1

Цагдаагийн ерөнхий газраас тус байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдлөг болгодог, дотоод үйл ажиллагааг зохицуулсан эрх зүйн актуудыг нэгтгэн системчилж “Монгол Улсын Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам”<sup>3</sup> (Standart Operating Procedure)-ыг боловсруулах ажлыг 2008 оноос эхлүүлсэн билээ<sup>4</sup>. Эдүгээ 9 бүлэг, 240 гаруй журмыг боловсруулан системчлэн кодчилж, батлуулж, 2011 онд анх удаа кодчилсон журмуудыг эмхэтгэн хэвлүүлжээ. Энэ ажлын хүрээнд тухайн үед хүчин төгөлдөр үйлчилж байсан Монгол Улсын 400 орчим хуулиас 90 гаруй хуулийн 166 зүйлээр цагдаагийн байгууллага, алба хаагчид үүрэг хүлээлгэсэн хэм хэмжээ тусгасан байсныг судлан тогтоожээ. Түүнчлэн тэдгээрийг хэрэгжүүлэх зорилгоор гаргасан зарлиг, тогтоол, дүрэм, журам, заавар, тушаал, үүрэг даалгавар зэрэг 450 гаруй эрх зүйн акт болон 1990 оноос хойш Цагдаагийн ерөнхий газрын даргын баталсан хэм хэмжээ тогтоосон 300 гаруй актыг судалжээ.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны дотоод журмыг боловсруулж, хэрэгжүүлснээр хууль дээдэлж, хүний эрх, эрх чөлөөг баталгаатай хангах, цагдаагийн ажил, үйлчилгээг эрх зүйн хүрээнд олон нийтэд хүртээмжтэй, шуурхай хүргэх, алба хаагчийн үйл ажиллагаа, ажлын гүйцэтгэл хууль ёсны, ил тод байх, мэргэжлийн ур чадвар дээшлэх, алба хаагчийн эрх, хууль ёсны эрх ашгийг хамгаалах нөхцөлийг бүрдүүлэх зэрэг ажил, үйлсэд ихээхэн ач холбогдолтой гэж үзсэн.

ЦЕГ-ын ажлын хэсэг цагдаагийн байгууллагын хэмжээнд хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай дотоод үйл ажиллагаа буюу процессын жагсаалтыг гаргаж, нийт 9 бүлэгт ангилсан байна (Хүснэгт 1).

<sup>3</sup> ЦЕГ, Ц.Арвинбуудай, Д.Эрдэнэбаатар, Л.Нямдаваа, “Монгол Улсын Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам” (Standart Operating Procedure), УБ. 2011

<sup>4</sup> ЦЕГ-ын даргын 2008 оны 502 дугаар тушаалаар Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын үйл ажиллагааны журмыг боловсруулах, системчлэн кодлох ажлын хэсгийг байгуулан ажиллуулсан. Хуулийн хэлтсийн алба хаагчдаар ахлуулсан ажлын хэсэг төсөл боловсруулж, цагдаагийн алба, нэгж, алба хаагчдаар хэлэлцүүлж, саналыг тусгасан.



## Хүснэгт 1. ЦБҮАЖ-ын ангилагч-1

д/д	Ангилал	Бүлгийн нэр	Журмын тоо
1	Нэгдүгээр бүлэг	Цагдаагийн байгууллагын зохион байгуулалт, захиргааны үйл ажиллагаа	21
2	Хоёрдугаар бүлэг	Цагдаагийн алба хаах харилцаа	39
3	Гуравдугаар бүлэг	Санхүү, ар тал	17
4	Дөрөвдүгээр бүлэг	Мэдээллийн технологи ба бусад	13
5	Тавдугаар бүлэг	Цагдаагийн алба хаагчийн нийтлэг үйл ажиллагаа	56
6	Зургадугаар бүлэг	Нийгмийн хэв журам хамгаалах	27
7	Долдугаар бүлэг	Цагдаагийн байгууллагын захиргааны үүрэг	35
8	Наймдугаар бүлэг	Эрүүгийн мөрдөн шалгах ажиллагаа	18
9	Есдүгээр бүлэг	Дотоодын цэргийн үйл ажиллагаа	5
	<b>Нийт</b>	<b>9 бүлэг</b>	<b>230</b>

Нийтдээ 9 бүлэгт ангилагдсан 230 процесс ажиллагааны жагсаалтыг бүлэг тус бүрт дараалуулан, гурван оронтой тоогоор илэрхийлсэн индексээр таних тэмдэгтэй болгож индексжүүлсэн байна.

ЦБҮАЖ-ыг 2008 оноос хойш 3 удаа (2011, 2014, 2018 онд) засан сайжруулж, нэмэлт оруулж, шинэчлэн эмхэтгэл болгон хэвлүүлсэн бөгөөд өнөөдөр 9 бүлэг, 258 журмыг үйл ажиллагаандаа дагаж мөрдөж байна. Нэмэлт өөрчлөлтийн талаар тодруулан авч үзвэл:

- Цагдаагийн байгууллагын удирдлага, зохион байгуулалт гэсэн Нэгдүгээр бүлэгт: Төрийн нууцыг хамгаалах (114), Цагдаагийн алба хаагчийн шинэ санал, санаачилгыг дэмжих (116), Мэдээллийн ил тод байдлыг хангах, сурталчлах (135), Байгууллагын даргын тушаал гаргах (136), Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны эрсдэлийн

- удирдлагыг хэрэгжүүлэх (137), Иргэний зөвлөлтэй харьцах (138), Цагдаагийн байгууллагын авилигаас урьдчилан сэргийлэх (139), Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх (140) гэсэн 8 журам нэмэгдсэний зэрэгцээ “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмыг боловсруулах, хэрэгжүүлэх журам”-ыг “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмыг боловсруулах, хэрэгжүүлэх үүрэг бүхий бодлогын зөвлөл ажиллах” гэж, “Албаны шалгалт явуулах журам”-ыг “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах” гэж, “Санхүүгийн үйл ажиллагааг үнэлж дүгнэх” журмыг “Санхүүгийн хяналт шалгалт хийх” гэж, “Галын аюулгүй байдлыг хангах” гэснийг “Гамшиг, галын аюулгүй байдлыг хангах, урьдчилан сэргийлэх” гэж тус тус өөрчилжээ.
- “Алба хаагчийн нийтлэг үйл ажиллагаа” гэсэн Хоёрдугаар бүлэгт Хэргийн газрын үзлэг хийх (206), Зам тээврийн ослын газрыг хамгаалах, үзлэг хийх (207), Тусгай хэрэгслийг хадгалах, хамгаалах, бүртгэх, тавьж олгох (236), Төрийн болон төрийн байгууллагатай хамтран ажиллах (240), Олон нийтийн цагдаагийн ажилтныг ажиллуулах (243), Тэмдэглэл, илтгэх хуудас үйлдэх (245) гэсэн журмуудыг шинээр боловсруулж; Цагдаагийн албаны автомашинтай холбоотой зам тээврийн осол, хэргийг шалгах, журмыг 4 дүгээр бүлгээс шилжүүлэн авч нийтдээ 7 журам нэмэгджээ. “Нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэх”, “Тээврийн хэрэгсэл албадан зогсоох тусгай хэрэгсэл хэрэглэх”, “Самбо, каратэ зэрэг зэвсэггүйгээр тулалдах мэх хэрэглэх”, “Албаны нохой сургах, хэрэглэх” журмууд нь “Галт зэвсэг, тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх” гэж байгаад одоо “Биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх” гэж өөрчлөгдсөн журамд багтаасан тул хасагдсан байна. “Гэрч хохирогчийг хамгаалах журам”-ыг “Олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа” гэсэн тавдугаар бүлэгт шилжүүлж, Цагдаагийн албаны хуулиар туслах ажилтны талаарх зохицуулалт хасагдсан тул “Туслах ажилтныг ажиллуулах” журмыг хүчингүй болгосон байна. “Гэмт хэргийн тухай мэдээллийг иргэдээс төлбөртэй авах” гэснээс “иргэдээс” гэдэг нь хасагдаж, “Түр саатуулах журам”-ын нэрийг “Захиргааны журмаар түр саатуулах” гэсэн байна.

- Гуравдугаар бүлэгт 26 журам багтаж байсан бол “Эрүүгийн хэргийн танилцуулга бичих”, “Хэрэг бүртгэх мөрдөн байцаах албаны даргаас эрүүгийн хэрэгт хяналт тавих”, “Эд мөрийн баримтыг хадгалах” журмууд шинээр нэмэгдэж, 4 дүгээр бүлгээс “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх” журмыг шилжүүлэн авч, зарим журмын нэрэнд өөрчлөлт оруулжээ.
- Дөрөвдүгээр бүлэгт 22 журам багтаж байсан бол хууль тогтоомжийн өөрчлөлттэй холбоотойгоор ердөө 10 журам хэвээр үлдэж, 11 журмыг тавдугаар бүлэг буюу шинээр нэмэгдсэн олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийн хүрээнд явуулах үйл ажиллагааг зохицуулсан бүлэгт шилжүүлжээ.
- Тавдугаар бүлэгт урьд нь дотоодын цэргийн үйл ажиллагааны нийтлэг зохицуулалтын 4 журам багтаж байсан бол одоо “Нийтийн хэв журам хамгаалах”, “Олон нийтийн аюулгүй байдлыг хангах”, “Дипломат төлөөлөгчийн газар, улсын онц чухал объектын харуул, хамгаалалтыг зохион байгуулах”, “Жагсаал, цуглааны үед олон нийтийн аюулгүй байдлыг хангах”, “Жагсаал, цуглааныг албадан тараах”, “Нийтийн эмх замбараагүй байдал үүссэн үед олон нийтийн аюулгүй байдлыг хангах”, “Онц байдал зарласан үед олон нийтийн аюулгүй байдлыг хангах”, “Төрийн болон гадаадын дээд хэмжээний зочин төлөөлөгчийн айлчлалын үед хамгаалалт зохион байгуулах”, “Төрийн тусгай хамгаалалтын байгууллагатай хамтран ажиллах”, “Гамшгийн үеийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа”, “Зорчигч, ачаа тээшийг тээврийн замд харгалзан хүргэх”, “Зарим объектыг хамгаалах, түр хамгаалалтыг зохион байгуулах”, “Гэрч, хохирогчийг хамгаалах”, “Улсын онц чухал объектод гадаадын иргэн нэвтрүүлэх, хяналт тавих, хамтран ажиллах”, “Харуулын заавар боловсруулах, мөрдөж ажиллах”, “Нууц үг батлах, дугаараар харьцах”, “Энхийг дэмжих ажиллагаанд оролцох” гэсэн 16 журмаас бүрдэж байна.
- Зургадугаар бүлэгт 32 журам багтаж байсан бол одоогийн байдлаар “Мөрийтэй тоглоом тоглуулах журмын биелэлтэд хяналт тавих” журмыг хүчингүй болгож, 2013 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн Цагдаагийн албаны тухай хуулиар захиргааны журмаар баривчлах шийдвэр биелүүлэх үүрэг нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх

байгууллагад шилжсэнтэй холбоотойгоор захиргааны журмаар баривчлах, албадан саатуулах шийдвэрийг биелүүлэх журмаас “баривчлах” гэсэн хэсгийг хасжээ.

- Долдугаар бүлэгт 14 журам багтаж байсан бол одоо “Судалгаа, хяналтын тоо бүртгэл хөтлөх”, “Цагдаагийн байгууллагын хууль сахиулах үүрэг бүхий хүч хэрэгслийн тоо бүртгэл хөтлөх”, “Жолоодох эрхийн үнэмлэх авсан хүний талаарх тоо бүртгэл хөтлөх” гэсэн гурван журам шинээр нэмэгдэж одоо 17 журам багтаж байна.
- Наймдугаар бүлгийн нэр “Санхүү, ар талын үйл ажиллагаа” гэснийг “Санхүү, хангамжийн үйл ажиллагаа” гэж өөрчлөн “Алба хаагчийг хөнгөлөлттэй нөхцөлөөр орон сууцанд хамруулах” гэж нэмээд одоо 16 журмыг багтаасан.
- Хүний нөөц, алба хаах харилцаа гэсэн Есдүгээр бүлэгт 48 журам багтаж байсан бол “Албан тушаал дэвшүүлэх, бууруулах” журмыг салгаж “Албан тушаал дэвшүүлэх”, “Албан тушаал бууруулах” гэж нэмсэн, “Хүний нөөцийн цахим санг ашиглах, түүний аюулгүй байдлыг хангах”, “Сургагч-багшийг бэлтгэх, чадавхжуулах, үнэлэх”, “Алба хаагчийн үргэлжилсэн сургалт зохион байгуулах” журмуудыг шинээр нэмсэн нэмэлт өөрчлөлтийг тус тус хийж, одоо 52 журам үйлчилж байна.

“Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам” мөрдөгдөж ирсэн 2010-2017 онд нийтдээ 244-252 журам үйлчилж ирснээс 26 журам нэмэгдэж, 8 журам хасагдсанаас үзэхэд харьцангуй тогтвортой мөрдөгдөж иржээ гэж үзэж болохоор байна.

## Хоёр. ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ БА ХҮНИЙ ЭРХ

Монгол Улс Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-д гишүүнээр элсэж, хүний эрхийн<sup>5</sup> талаарх олон улсын 30 гаруй гэрээнд нэгдэн орж, НҮБ-д хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх үйлсэд зохих амжилт олсоор ирсэн.<sup>6</sup> НҮБ хүний эрхийг баталгаажуулах хүрээнд олон чухал баримт бичгийг баталсны дотор Хүний эрхийн түгээмэл тунхаглал (1948), Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт (1966), Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (1966) нь “Хүний эрхийн билл” буюу үндсэн баримт бичгүүд юм.

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын оршил хэсэгт “хүмүүсийн эзэрхэг засаглал, дарлалын эсрэг өөрийн эрхгүй эцсийн арга болгон зэвсэглэн босоход хүргэхгүйн тулд хүний эрхийг хуулиар (rule of law) хамгаалах нь нэн чухал”<sup>7</sup>-ын учир түүнийг тунхаглаж буйгаа зарласан билээ.

НҮБ-ын тогтолцооны хэд хэдэн байгууллагаас<sup>8</sup> хууль сахиулах үйл ажиллагаанд хүний эрхийг хангахтай холбоотой олон улсын стандартуудыг боловсруулж, НҮБ-ын Ерөнхий Ассамблей, Эдийн засаг, нийгмийн зөвлөл баталснаар хууль сахиулах үйл ажиллагаанд нийтээр дагаж мөрддөг болсон ба НҮБ-ын гишүүн улс нь эрх зүйн тогтолцоо, эсвэл үндэсний эрх зүйн хүрээ зэргээс үл хамааран дагаж мөрдөхөөр хүлээн зөвшөөрсөн гэсэн үг юм. Тэдгээрээс НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1979 оны 34/169 тогтоолоор баталсан “Хууль хэрэгжүүлэх албан тушаалтнуудын зан үйлийн тухай хууль”, НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн зөвлөлийн 1989 оны 1989/61 дүгээр тогтоолоор баталсан “Нийгмийн хэв журам сахиулах үүрэг бүхий албан тушаалтнаас хүч хэрэглэх болон галт зэвсэг хэрэглэх үндсэн зарчим”, Европын Зөвлөлийн Сайд нарын Зөвлөлөөс гаргасан “Цагдаагийн ёс зүйн тухай Европын хэм хэмжээний талаарх зөвлөмж”, НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссаруудын газраас

<sup>5</sup> “Хүний эрх” гэдэг нь чөлөөтэй амьдрах, аж төрөх жам ёсны ба нийгэм, эдийн засаг, соёлын, бусад боломж бөгөөд дэлхийн II дайны дараа 1945 онд НҮБ байгуулагдсан цагаас хойш өдөр тутмын хэллэгт орж ирсэн ойлголт юм.

<sup>6</sup> Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр. УИХ-ын 2003 оны 41 дүгээр тогтоолын хавсралт. <http://www.legalinfo.mn/annex/details/3225?lawid=6265>

<sup>7</sup> Хүний эрхийн түгээмэл тунхаглал. <http://www.legalinfo.mn/law/downloadPdf/1271/>

<sup>8</sup> Хүний эрхийн комисс, Цөөнхийг ялгаварлан гадуурхах, цаазлах ялын эсрэг комисс, НҮБ-ын Гэмт хэргийг урьдчилан сэргийлэх, гэмт этгээдийг засан хүмүүжүүлэх Конгресс зэрэг.

гаргасан “Цагдаагийн албан хаагчийн үйл ажиллагаанд баримтлах олон улсын хүний эрхийн стандарт”, “НҮБ-ын цагдаагийн хууль сахиулах үйл ажиллагааны стандарт” зэргийг дурдах нь зүйтэй.

Орчин үед аюулгүй байдал, хөгжил, хүний эрх нь тусдаа ойлголт биш, цогцоор анхаарах асуудал тул “Хүний эрхийн билл” болох Хүний эрхийн түгээмэл тунхаглал, хоёр пактыг төрийн, тэр дундаа хууль сахиулах байгууллагын алба хаагч бүр мэдэж, дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил хэрэглэснээр хүний эрх, эрх чөлөөг баталгаатай эдлүүлэх үүргээ биелүүлэх, иргэдийнхээ амар амгалан, сайн сайхан байдлыг хангах үндэс болох билээ.

НҮБ-аас эрхлэн гаргасан “Цагдаагийн багууллагын хүний эрхийн стандарт ба туршлага”-д хууль сахиулах байгууллагын албан хаагчид нь олон улсын хүний эрхийн стандартуудыг мэдэх, хэрэглэх үүрэг хүлээнэ<sup>9</sup> гэж заасан. Уг стандартад цагдаагийн байгууллагаас хүний эрхийг ханган ажиллахад дараах асуудлуудыг зөвлөмж болгожээ. Үүнд:

- Өөрийн байгууллагадаа зориулсан хүний эрхийн цогц бодлого батална;
- Дүрэм, журмыг хүний эрхийн стандартуудтай нийцүүлнэ;
- Цагдаа нарыг анх ажилд ороход болон түүнээс хойш, давтамжтайгаар хүний эрхийн сургалтад хамруулна;
- Үндэсний болон олон улсын хүний эрхийн байгууллагуудтай хамтран ажиллана г.м.

Монгол Улсын Үндсэн хууль (1992)-иар<sup>10</sup> хэнийг ч ялгаварлан гадуурхахгүй байх зарчим, хүний салшгүй эрхүүд, бусад эрх, эрх чөлөөг баталгаажуулсан<sup>11</sup>. Тухайлбал, уг хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь хэсэгт: “халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно” гэж заасан. Мөн Засгийн

<sup>9</sup> Human Rights Standards and Practice for the Police. Office of the United Nations High Commissioner for Human Rights. UNITED NATIONS. New York and Geneva, 2004. Professional Training Series No. 5/Add.3

<sup>10</sup> Монгол Улсын Үндсэн хууль. 1992 он. //http://www.legalinfo.mn/law/details/367

<sup>11</sup> “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ”; “Монгол Улс Үндсэн хуульдаа харшилсан олон улсын гэрээ, бусад баримт бичгийг дагаж мөрдөхгүй”. Монгол Улсын Үндсэн хуулийн 10.3; 10.4 дэх хэсэг.

газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.3-т “Хууль заавал хэрэгждэг, хүн бүрт эрх тэгш, алагчлалгүй, шударга үйлчилдэг, итгэл хүлээсэн хүний эрхийн мэдрэмжтэй, шударга ёсны засаглалыг бэхжүүлэх зарчмыг баримтална” гэжээ.

Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг Цагдаагийн албаны тухай хууль (ЦАТХ)-д дараах байдлаар баталгаажуулжээ. Үүнд:

1. Хүний эрхийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, үндсэн агуулгыг уг хуулийн 22.1-т заахдаа “Цагдаагийн байгууллага, алба хаагч нь хуулийг чанд сахиж, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэж, үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлахгүйгээр хүний эрх, эрх чөлөөг хамгаалах үүрэгтэй”;
2. Үндсэн хуулийн “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах” иргэний эрхийг уг хуулийн 96.1-т тусгасан: “Цагдаагийн байгууллага, алба хаагчийн буруутай үйл ажиллагаа, шийдвэрээс хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн гэж иргэн, албан тушаалтан үзвэл дотоод хяналт-аюулгүй байдал хариуцсан нэгж болон прокурор, шүүхэд гомдол гаргах эрхтэй”;
3. Цагдаагийн байгууллага нь нэг талд хохирогчийн эрхийг хамгаалж ажиллахаас гадна гэмт хэрэг, зөрчил үйлдэж эрх нь хязгаарлагдсан этгээдийн эрхийг ханган ажиллана. Энэ талаар тус хуулийн 22.2-т: “Цагдаагийн алба хаагч нь хуульд заасан үндэслэл, журмын дагуу хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан, эсхүл албадлагын арга хэмжээ авсан тохиолдолд арга хэмжээ авах болсон үндэслэл, шалтгааныг тухайн этгээдэд мэдэгдэж, авсан арга хэмжээтэй холбогдон хүн, хуулийн этгээдэд үүсэх эрх, үүрэг, өмгөөлөгч авах, өөрийгөө өмгөөлөх, өөрийнхөө эсрэг тайлбар, мэдүүлэг өгөхгүй байх эрхийг тайлбарлаж өгөх үүрэгтэй”;
4. Мөн хуульд хүний эрхийг хангаж ажиллахаар чухал заалтууд орсон. Тухайлбал, Хүний эрх, эрх чөлөөг үндэслэлгүйгээр зөрчсөн бол цагдаагийн байгууллага уучлал гуйх ба зөрчигдсөн эрхийг сэргээж,

учирсан хохирлыг төр хариуцан арилгана. Хохирол барагдуулахад гарсан зардлыг буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ<sup>12</sup> гэж тус тус заасан.

Үүний зэрэгцээ цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны 258 журмын 60 гаруйд нь хүнийг эрхийг хангах, хамгаалах заалт тусжээ. Тухайлбал, Зарим хөтөлбөр, төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх<sup>13</sup> (код 109), Цагдаагийн алба хаагчийн шинэ санал, санаачилгыг дэмжих (код 116), Шуурхай удирдлагын албаны үйл ажиллагаа (код 200), Хүний бие, тээврийн хэрэгсэл, ачаа тээшид үзлэг хийх (код 215), Шинжилгээнд зориулж дээж, дардас, хэв хэлбэр, загвар авах (код 219), Согтууруулах ундаа, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх, хордуулах бодис хэрэглэсэн эсэхийг шалгах (код 220), Гэмт хэрэг, зөрчил үйлдсэн хүнийг баривчлах, төрийн байгууллагад хүргэх (код 223), Гэмт хэрэг, зөрчил үйлдсэн хүнийг баривчлах, төрийн байгууллагад хүргэх (код 223), Эрэн сурвалжлах (код 243), Олон нийтийн цагдаагийн ажилтныг ажиллуулах (код 229), Гэмт хэрэг илрүүлэх ажиллагаанд полиграф ашиглах (код 302), Банк, банк бус санхүүгийн Байгууллагаас мэдээлэл авах (код 303), Гүйцэтгэх ажил явуулах (код 307), Хүүхдийн эрхийг хангах (код 316), хэрэг бүртгэх, мөрдөн байцаах албаны даргаас эрүүгийн хэрэгт хяналт тавих (код 328), Жагсаал, цуглааныг албадан тараах (код 503), Онц байдал зарласан үед олон нийтийн аюулгүй байдлыг хангах (код 505), Албадан нүүлгэх тухай засаг даргын шийдвэрийг биелүүлэх, эсэргүүцсэн бол арга хэмжээ авах (код 604), Төмөр замын гармын зэрэглэл тогтооход санал өгөх (код 612), Албадан саатуулах (код 622), Сонгуулийн санал хураах байр хамгаалах (код 623), Гадаадын иргэний талаарх мэдээлэл солилцох (код 626), Албадан эрүүлжүүлэх (код 629) гэх зэрэг олон журмыг дурдаж болно.

<sup>12</sup> Цагдаагийн албаны тухай хууль. 96.4 дүгээр зүйл (шинэчилсэн найруулга). 2017

<sup>13</sup> Зарим хөтөлбөр, төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх журам (код 109)-ын 109.7.1: “Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг цагдаагийн байгууллагын хэмжээнд хэрэгжүүлэх болон түүний биелэлтийг хангуулах чиглэлээр гарсан тушаал шийдвэрүүдийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийн явц байдал, үр дүнг тооцох, дээд байгууллага, албан тушаалтанд танилцуулах үүрэг бүхий салбар хороог цагдаагийн төв байгууллагын дарга удирдана” гэж заажээ.



## Гурав. ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ ХҮНИЙ ЭРХЭД НИЙЦСЭН ЭСЭХ

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд баримтлах хүчин төгөлдөр мөрдөгдөж буй 9 бүлэг, 258 кодчилсон журам (ЦБҮАЖ)-аас гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хүний эрх, эрх чөлөөг хязгаарлаж, хөндөж байгаа гэсэн шалгуураар 132 журмыг сонгон авлаа. ЦБҮАЖ хүний эрхэд нийцсэн байдлыг тогтоох шалгуур үзүүлэлтийг гаргахдаа цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны явцад хөндөгдөж болзошгүй эрхийг сонгон авч, шалгуур үзүүлэлтийг боловсруулав.

### Хүснэгт 2. Хүний эрхийн шалгуур

Хүний эрх	Шалгуур үзүүлэлт
Хүн бүр амьд явах	Амьд явах эрхэд эрсдэл учруулж болзошгүй заалт бий эсэх
	Хүний эрүүл мэндийг нөхөн сэргээхэд шаардлагатай төлбөр гаргуулах эрхийг баталгаажуулсан эсэх
Эрүүл, аюулгүй орчинд амьдрах	Иргэдийн аюулгүй орчинд амьдрах эрхийг баталгаажуулсан дүрэм журам бий эсэх
Хэнд ч эрүү шүүлт тулган эсхүл хэнтэй ч хэрцгийгээр, хүний ёсноос гадуур буюу нэр төрийг нь доромжлон харьцах, шийтгэх ёсгүй.	Айлган сүрдүүлэх, шахалт үзүүлэх, аливаа байдлаар ялгаварлан гадуурхахыг хориглосон заалт бий эсэх
	Эрүүдэн шүүх үйлдэл үйлдэгдсэн гэж үзэх хангалттай үндэслэл байвал мөрдөн шалгах ажиллагааг эрх бүхий байгууллагаараа шударга, шуурхай явуулах заалт бий эсэх
	Эрүүдэн шүүгдсэн хэмээн мэдүүлж буй этгээд эрх бүхий байгууллагад гомдол гаргах, хэргээ шуурхай, шударгаар хянан шалгуулах, холбоотой мэдээллээр хангуулах эрхийг заасан эсэх

Хүний эрх	Шалгуур үзүүлэлт
	<p>Аливаа хэлбэрээр баривчлагдсан, саатуулагдсан, хоригдсон этгээдийг харгалзах, байцаах, харьцах, хууль сахиулах албан тушаалтанд эрүүдэн шүүхийг хориглох тухай сургалт явуулах, сургалтын материал, мэдээлэлд бүрэн тусгах талаар заалт бий эсэх</p> <p>Албан үүрэг гүйцэтгэж буй бусад хүний өдөөн хатгалт, ил, далд зөвшөөрлөөр тухайн хүн буюу гурав дахь этгээдийн бие махбодь, сэтгэл санааг хүчтэй шаналган зовоох аливаа санаатай үйлдлийг хориглосон эсэх</p> <p>Эрүүдэн шүүхийг зөвтгөх үндэслэл бүхий заалт бий эсэх</p>
<p>Хүн бүр хуулийн өмнө адил тэгш бөгөөд ямар ч алагчлалгүйгээр хуулиар адилхан хамгаалуулах эрхтэй. Хүн бүр энэхүү Тунхаглалд харшлах аливаа алагчилалаас болон тийнхүү алагчилахыг өдөөсөн турхиралтаас адилхан хамгаалуулах эрхтэй.</p>	<p>Яс үндэс, жендэр, шашин, хэл, арьсны өнгө, улс төрийн байр суурь, үндэс угсаа, өмч, төрсөн болон бусад байдалд үндэслэн ялгаврлаж болохгүй талаар заалт байгаа эсэх</p> <p>Ялгаварлан гадуурхагдсан гэж үзэж буй иргэдийн гомдол, санал хүсэлтийг тасралтгүй хүлээн авах механизмыг бүрдүүлэх асуудлыг зохицуулсан эсэх</p> <p>Ялгаварлан гадуурхаж, аль нэг бүлэгт давуу байдал үүсгэсэн зохицуулалт агуулсан эсэх</p> <p>Энэ нь тодорхой бүлгийн эмзэг байдлыг дээрдүүлэхийн тулд авч буй түр тусгай арга хэмжээ мөн бол олон улсын болон үндэсний хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж буй эсэх</p> <p>Хэрэв энэ нь түр тусгай арга хэмжээ биш бол ямар зорилгоор тусгасныг тайлбарласан эсэх</p>
<p>Халдашгүй дархан байх, хэнийг ч дур мэдэн баривчлах, саатуулах буюу хөөн зайлуулах ёсгүй.</p>	<p>Баривчлах, саатуулах, хорихтой холбоотой журам, заавар тусгайлан боловсруулж батлагдсан эсэх</p> <p>Хуульд заасан үндэслэлээс өөр үндэслэлээр баривчлах, саатуулахтай холбоотой заалт байгаа эсэх</p> <p>Ямар шалтгааны улмаас баривчлах, саатуулж байгаа талаар мэдэгдэх заалт байгаа эсэх</p>

Хүний эрх	Шалгуур үзүүлэлт
	Баривчлагдсан, саатуулагдсан хүнд эрхийг тайлбарлах тухай заалт бий эсэх
	Өмгөөлөгч, эсхүл өөр хууль зүйн төлөөлөгчтэй болох (авах), тухайн төлөөлөгчтэй харилцаа холбоо тогтоох талаар заасан эсэх
	Баривчилсан, саатуулсан тухай тэмдэглэлд баривчлах болсон шалтгаан, баривчилсан хугацаа, баривчлагдсан хүнийг хорих газар, шүүх байгууллага руу шилжүүлсэн, очсон хугацаа, ажиллагаанд оролцсон албан хаагчдын тодорхойлолт, хорих газрын талаарх тодорхой мэдээлэл, байцаалтын талаар дэлгэрэнгүй мэдээлэл тусгахаар заасан эсэх
	Баривчилсан, саатуулсан тухай тэмдэглэлийг саатуулагдсан хүнд, эсхүл түүний хууль ёсны зөвлөх, түүний гэр бүлд түүнийг баривчлан саатуулсан болон хорих газрын талаар мэдэгдэхтэй холбоотой заалт бий эсэх
	Цагдаагийн алба хаагчаас баривчлах, саатуулах үйл ажиллагааг хүний эрхэд нийцсэн байхаар хэрэгжүүлэхтэй холбоотой зөвлөмж бүхий заалтууд бий эсэх
	Баривчлагдсан, саатуулагдсан этгээдийг хянан харгалзах, харьцах журам, арга хэмжээнд шат дараалсан хяналт тавих талаар заасан эсэх
	Үзлэг, нэгжлэг хийх журам хүний эрхийн зарчим, хууль тогтоомжид нийцсэн эсэх
	Хүнийг хууль бусаар мөрдөн мөшгөх агуулга бүхий журам бий эсэх
	Эрүүлжүүлэх ажиллагааны тусгайлсан стандарт байгаа эсэх
	Эрүүлжүүлэх байрны стандартыг тогтоож өгсөн эсэх
	Эрүүлжүүлэх үйл ажиллагаанд хүний эрхийг хангах талаарх заалт бий эсэх

Хүний эрх	Шалгуур үзүүлэлт
	Эрүүлжүүлэх байрны үйл ажиллагаанд хяналт тавих заалт бий эсэх
	Албадан эмчилгээ хийх, эмчилгээнд явуулах тусгайлсан журам бий эсэх
	Хүний эрхийг хангах талаар заалт бий эсэх, боловсруулсан эсэх
Шударга шүүхээр шүүлгэх эрх	Оногдуулж байгаа ялын шинж чанар, үндэслэлийг ойлгох хэлээр нэн даруй мэдэгдэж буй эсэх
	Өмгөөлөх, өмгөөлүүлэх
	Өөрийнх нь эсрэг мэдүүлэг өгч байгаа гэрчийг байцаалгах, байцаалгуулах, өөр гэрч дуудах боломжийг хангасан эсэх
	Зүй бусын хойшлуулалтгүйгээр шүүгдэх боломжийг хангасан эсэх
	Өөрийн мэддэг хэлээр мөрдөн шалгах ажиллагаанд оролцох, үгүй бол орчуулагчийн туслалцаа авах
Хэний ч хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн оролцох, захидал харилцааных нь нууц болон нэр төр, алдар хүндэд нь халдах ёсгүй. Тийм оролцоо халдлагын эсрэг хэн ч бай хуулиар хамгаалуулах эрхтэй.	Хуульд заасан үндэслэлээс гадуур гэр бүл, хувь хүний нууцад халдах талаар заасан эсэх
	Гэр бүл, хувь хүний нууцыг олж авсан алба хаагчид бусдад тараахыг хориглосон заалт бий эсэх
	Захидал харилцааны нууцыг хадгалах заалт бий эсэх
	Хүний нэр төр, алдар хүндийг хамгаалахтай холбоотой заалт бий эсэх
	Гэр бүл, хувийн, захидал харилцааны нууцыг хуульд зааснаас өөр үндэслэлээр ил болгох заалт бий эсэх

Хүний эрх	Шалгуур үзүүлэлт
Орон байрны халдашгүй байдал	Орон байранд хяналт тавих, нэвтрэн орох тусгайлсан журам боловсруулсан эсэх
	Орон байранд хяналт тавих, нэвтрэн орох талаар хуульд зааснаас өөр үндэслэл тусгасан эсэх
	Орон байрны халдашгүй байдлыг хамгаалсан зохицуулалт бий эсэх
	Орон байранд нэвтрэн орох тодорхой үндэслэлийг тусгасан эсэх
	Орон байранд нэвтрэх орох, зөвшөөрөл авах талаар зохицуулсан эсэх
Хэн боловч улсынхаа дотор чөлөөтэй зорчих, оршин суух газраа чөлөөтэй сонгох эрхтэй. Хэн боловч аливаа улс орныг, түүний дотроо эх орноо орхин явах, эх орондоо эргэж очих эрхтэй.	МУ-ын нутаг дэвсгэрээс гарахыг түдгэлзүүлэх тусгайлсан журам боловсруулсан эсэх
	Гадаад улс руу зорчих эрхийг хязгаарлах үндэслэлийг зааж өгсөн эсэх
	Улсынхаа дотор зорчих эрхийг хязгаарласан, хуульд зааснаас өөр үндэслэл бий эсэх
Хэн боловч мөрдөлт мөшгөлтөөс зугтаж, өөр улсад орогнох боломжийг эрэлхийлэх болон орогнох эрхтэй. Улс төрийн бус гэмт хэргийн улмаас буюу НҮБ-ын зорилго, зарчимд харш хэрэг үйлдсэний улмаас зайлшгүй мөрдөгдөж буй тохиолдолд дээрх эрхийг эдэлж үл болно.	Эх орноо орхин явахыг хязгаарлах үндэслэл байгаа эсэх
	Өөр улсад орогнох, цагаачлах эрхийг хязгаарлах талаар зохицуулсан заалт бий эсэх
	Хуульд заасан үндэслэлээс гадна өөр зохицуулалтыг тусгасан эсэх
	Эрүүдэн шүүгдэх үндэслэл бүхий нөхцөл байдалд албадан гаргахгүй байх тухай зарчмыг тусгасан эсэх
	Улс төрийн бус гэмт хэргийн улмаас мөрдөлт мөшгөлтөөс зугтаж, орогнол хүссэн тохиолдолд цагдаагийн байгууллагын гүйцэтгэх үүргийн талаар зохицуулсан эсэх

Хүний эрх	Шалгуур үзүүлэлт
Гэр бүл бол нийгмийн жам ёсны үндсэн нэгж мөн бөгөөд нийгэм, төрөөр хамгаалуулах эрхтэй.	Гэмт хэргийн гэрч, хохирогч (гэмт хэрэгтэн этгээд)-ийн гэр бүлийн гишүүдийг хамгаалахтай холбоотой журам боловсруулагдсан эсэх
	Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүний эрхийг хамгаалах талаар заалт бий эсэх
	Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүнийг хамгаалах байрны стандартыг заасан эсэх
	Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүнийг хамгаалах байрны үйл ажиллагааны тусгайлсан стандарт бий эсэх
	Хамгаалах байрны үйл ажиллагаанд хяналт тавих заалт бий эсэх
	Хүүхдийн эрхийг хамгаалахтай холбоотой заалт бий эсэх
Хүн бүр эд хөрөнгийг ганцаараа буюу бусадтай хамтарч өмчлөх эрхтэй. Хэний ч өмч хөрөнгийг дураар хураан авч болохгүй.	Хувийн өмчийг хураан авахад анхаарах асуудлын талаар заалт бий эсэх
	Хувийн өмчийг хуульд зааснаас өөр үндэслэлээр хураан авах талаар зохицуулалт байгаа эсэх
	Хураан авах үйл ажиллагааны явцад хүний эрхийг хамгаалах талаар заалт бий эсэх
	Түр хураан авч байгаа тохиолдолд тэмдэглэл үйлдэж баримтжуулах, хураалгаж буй хүнд хувийг өгөх талаар заасан эсэх
	Хураасан эд зүйлийг хадгалах, хамгаалах талаар тусгайлан заасан эсэх
	Хувийн өмчийг хурааж авахаар бол нөхөн олговор олгох заалт бий эсэх

Хүний эрх	Шалгуур үзүүлэлт
<p>Хүн бүр чөлөөтэй бодож сэтгэх, шашин шүтэх, эс шүтэх эрхтэй. Энэхүү эрхэд шашин буюу шүтлэгээ өөрчлөх эрх чөлөө, бие даан буюу бусадтай хамтран нийтийн өмнө болон хувийн журмаар хичээл заах, хурал мөргөл хийх, шашны хийгээд зан үйлийн ёслол үйлдэх зэргээр шашин буюу шүтлэгээ номлох эрх чөлөө багтана.</p>	<p>Цагдаагийн байгууллагаас иргэний шашин шүтэх, эс шүтэх эрхийг хязгаарлах талаар заасан эсэх</p> <p>Бие даан, эсхүл бусадтай хамтран нийтийн өмнө болон хувийн журмаар шашны тухай хичээл заах, хурал мөргөл хийх, шашны хийгээд зан үйлийн ёслол үйлдэх зэрэг эрхийг хязгаарласан хуулиас гадуур заалт бий эсэх</p>
<p>Хүн бүр өөрийн үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрхтэй.</p>	<p>Хүн бүр өөрийн үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрхийг хязгаарлах үндэслэлийг тусгасан эсэх</p> <p>Хуульд заасан үндэслэлээс гадуур үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хязгаарласан эсэх</p> <p>Иргэд мэдээллийг улсын хилийн заагаар үл хязгаарлан аливаа арга замаар эрж сурвалжлах, хүлээж авах, түгээн дэлгэрүүлэх эрх чөлөөг хязгаарласан заалт бий эсэх.</p>

Хүний эрх	Шалгуур үзүүлэлт
Хүн бүр чөлөөтэй, тайван хуран цуглах, эвлэлдэн нэгдэх эрхтэй. Хэнийг ч аливаа эвлэл холбоонд албадан оруулах ёсгүй.	Цагдаагийн байгууллагаас иргэний чөлөөтэй, тайван хуран цуглах, эвлэлдэн нэгдэх эрхийг хязгаарласан заалт бий эсэх
	Нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхийг хязгаарласан заалт бий эсэх
	Жагсаал, цуглааны үед хүний эрхийг хамгаалах заалт бий эсэх
	Хуульд заасан үндэслэлээс гадна жагсаал цуглааныг албадан тараах журам бий эсэх
	Албадан тараах үйл ажиллагаанд хүнийг эрхийг хангах талаар заасан эсэх
Хүн бүр улсаа удирдахад шууд буюу чөлөөтэй сонгосон төлөөлөгчөөрөө уламжлан оролцох эрхтэй. Хүн бүр улсдаа төрийн алба хаших тэгш эрхтэй. Ард түмний хүсэл зориг бол засгийн эрх мэдлийн үндэс байх ёстой.	Хүн бүр улсаа удирдахад шууд буюу чөлөөтэй сонгосон төлөөлөгчөөрөө уламжлан оролцох эрхийг хязгаарлахтай холбоотой заалт бий эсэх
	Хүн бүр улсаа удирдахад шууд буюу чөлөөтэй сонгосон төлөөлөгчөөрөө уламжлан оролцох эрхийг ЦБ-аас хязгаарлахтай холбоотой журам боловсруулагдсан эсэх
	Сонгох, сонгогдох эрхийг хуульд заасан үндэслэлээс өөрөөр хязгаарласан эсэх
	Ялтай байх хугацаа нь төрийн алба хаших эрхийг хязгаарлахтай холбоотой заалт бий эсэх
Хүн бүр нийгмийнхээ соёлын амьдралд чөлөөтэй оролцох, урлагийн цэнгэлийг эдлэх, шинжлэх ухааны дэвшилд оролцож үр шимийг нь хүртэх эрхтэй.	Журамд нийгмийнхээ соёлын амьдралд чөлөөтэй оролцох, урлагийн цэнгэлийг эдлэх, шинжлэх ухааны дэвшилд оролцож үр шимийг нь хүртэх эрхийг хязгаарлах заалт бий эсэх



Хүний эрх	Шалгуур үзүүлэлт
Хүн бүр өөрийн туурвисан шинжлэх ухаан, утга зохиол, уран сайхны бүтээлийн материаллаг болон ёс суртахууны эрх ашгаа хамгаалуулах эрхтэй.	Цагдаагийн алба хаагч өөрийн туурвисан шинжлэх ухаан, утга зохиол, уран сайхны бүтээлийн материаллаг болон ёс суртахууны эрх ашгаа хамгаалуулах эрхтэй холбоотой заалт бий эсэх.
	Журамд цагдаагийн байгууллага, албан тушаалтан нь иргэдийн энэ тухай өргөдөл, гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх үүргийн тухай заалт бий эсэх.
Хөдөлмөрлөх эрх	Хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах боломжийг хангасан эсэх
	Нэг бүрийн, хамгаалах тусгай хэрэгслээр хангах асуудлыг оновчтой зохицуулсан эсэх
	Ажлын байрны шаардлагад нийцэхүйц ур чадвар, мэдлэгийг олгох сургалтын хөтөлбөр буй эсэх
Эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах	Амь насанд аюул тохиолдож буй үед яаралтай туслалцаа үзүүлэх боломж нөхцөлийг бүрдүүлсэн эсэх
Төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх	Өргөдөл, гомдлыг үр дүнтэй, шалгаж шийдвэрлэх асуудал туссан эсэх

Сонгож авсан 132 журмыг дээрх шалгуур үзүүлэлтээр үнэлсэн бөгөөд журам тус бүрд хамаарах хүний эрхийн шалгуур үзүүлэлтийг авч үзлээ. Үнэлгээ хийх явцад эдгээр журмыг хүний эрхийн хэм хэмжээ, хууль тогтоомжид нийцсэн, хүний эрхийн хэм хэмжээ, хууль тогтоомжтой зөрчилдөж байгаа, хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжид нийцээгүй, дотогшоо чиглэсэн гэсэн байдлаар 4 ангилан авч үзэхээр байна. Нийт 132 журмаас 45 журмыг цаашид хэвийн мөрдөж, үлдсэн 87 журамд ямар нэг нэмэлт, өөрчлөлт оруулах, үгүй бол бүхэлд нь шинээр боловсруулах хэрэгцээ шаардлага ажиглагдлаа.

## 3.1. Хүний эрхийн хэм хэмжээ, хууль тогтоомжид нийцсэн журмууд

Хүснэгт 3.

№	Журмын код, нэр
1	221. Нутаг дэвсгэр, орон байранд нэвтрэн орох, гарахад хяналт тогтоох
2	227. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх
3	228. Гэмт хэргийн тухай мэдээллийг төлбөртэй авах
4	229. Эрэн сурвалжлах
5	231. Тээврийн хэрэгслийг эрэн сурвалжлах
6	234. Биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх
7	240. Төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах
8	314. Гэмт хэргийн холбогдогчийг шилжүүлэх ажиллагаа
9	315. Монгол улсаас гарахыг түр түдгэлзүүлэх
10	318. Түүх, соёлын дурсгалт зүйлийг гадаад улсаас эргүүлэн авч ирэх
11	319. Ял эдэлж буй ялтныг шилжүүлэн авах
12	321. Сэтгэцийн өвчтэй хүний үйлдсэн гэмт хэрэг, зөрчлийг шалгах
13	322. Түдгэлзүүлсэн хэрэгт хийх ажиллагаа
14	323. Эрүүгийн хэрэг, материалыг дугаарлах
15	324. Уулзалт, байцаалтын хэсгийн үйл ажиллагаа
16	327. Эрүүгийн хэргийн танилцуулга бичих
17	328. Мөрдөн байцаах, эрүүгийн цагдаагийн албаны даргаас эрүүгийн хэрэгт хяналт тавих
18	329. Эд мөрийн баримтыг хадгалах, хамгаалах
19	403. Морьт эргүүл хийх
20	408. Зөрчлийг хянан шийдвэрлэх
21	504. Нийтийн эмх замбараагүй байдал үүссэн үед олон нийтийн аюулгүй байдлыг хангах
22	506. Төрийн болон гадаадын дээд хэмжээний зочин төлөөлөгчийн айлчлалын үед хамгаалалт зохион байгуулах
23	507. Төрийн тусгай хамгаалалтын байгууллагатай хамтран ажиллах
24	509. Зорчигч, ачаа тээшийг тээврийн замд харгалзан хүргэх

№	Журмын код, нэр
25	600. Цагдаагийн байгууллагын гүйцэтгэх захиргааны хяналтын үүрэг
26	603. Галт зэвсгийн бүртгэл, хөдөлгөөний мэдээ гаргах
27	607. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг тээвэрлэх зөвшөөрөл олгох
28	609. Ой хээрийн түймэртэй тэмцэх дайчилгаанд оролцох
29	610. Тээврийн хэрэгсэл жолоодох зөвшөөрөл олгоход хураамж авах
30	613. Мэргэжлийн хяналтын байгууллагатай хамтран ажиллах
31	614. Эцэг, эх нь хэн болох нь тогтоогдоогүй олдмол хүүхдийг бүртгэх
32	615. Сэтгэцийн өвчтэй хүнийг эрж олоход туслах
33	618. Шүүхэд хариуцагчаар оролцох хүнийг эрэн сурвалжлах
34	623. Сонгуулийн санал хураах байр хамгаалах
35	625. Гадаадын иргэний талаарх мэдээлэл солилцох

## 3.2. Хүний эрхийн хэм хэмжээ, хууль тогтоомжтой зөрчилдсөн журмууд

Хүснэгт 4.

№	Журмын холбогдох заалт	Асуудал, дүгнэлт	Зөвлөмж
1	<b>201. НОЦТОЙ ГЭМТ ХЭРГИЙН ТАЛААР МЭДЭЭЛЭХ</b>		
	201.1 Зорилго: ...ноцтой гэмт хэрэг...	Ноцтой гэмт хэрэг гэсэн нэр томъёог тодотгох.	Ноцтой гэмт хэрэг гэсэн нэр томъёог шинэчлэх, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэх.
	201.2 л/ "...төр засгийн байгууллагад хандан шаардлага тавьж буй өлсгөлөн, суулт, жагсаал, цуглааны талаар"...	Хүний эрхээ эдэлж буй үйлдлийг ноцтой гэмт хэрэгт хамруулж үзсэн.	Энэ хэсгийг хасах, эсхүл өөрчлөн найруулах.
2	<b>203. ХЭРГЭЭ ИЛЧЛЭН ИРСЭН ХҮНИЙ МЭДЭЭЛЛИЙГ ХҮЛЭЭН АВАХ</b>		
	203.3.2	"Төлбөрийн чадваргүй иргэдийн хувьд тодотгох".	"Төлбөрийн чадваргүй бол үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа авах боломжтой болохыг сануулах" гэж нэмэх.
	203.3.7 г/ хэргээ илчлэн ирсэн хүнд үзлэг хийх, шинжилгээнд ...	"журмын дагуу" гэснийг тодотгох.	Тус бүрт хамаарах ЦБҮАЖ-ыг заах.

№	Журмын холбогдох заалт	Асуудал, дүгнэлт	Зөвлөмж
3	<b>205. ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН ГАЗРЫГ ХАМГААЛАХ</b>		
	205.3 Алба хаагчийн хүлээх үүрэг: 205.3.1-ийн в/ хэрэг зөрчлийн газрыг бүхэлд нь буюу төв цэгээс 10-50 метрийн тойрогт хамгаалалтын бүс тогтоож, ...	205.3.1-ийн в хэсэгт: хэргийн газрын хилийг зөв тогтооход анхаарах зүйлүүдийг тодотгон зөвлөн зааварчлах.	205.3.1-ийн в хэсэгт: хэргийн газрын хилийг тогтооход анхаарах (жишээ нь орон байрны унтлагын өрөөнд хүн амины хэрэг гарсан бол бүх гэрийг, түүнчилэн орц, хашаа зэргийг хамгаалалтад авах), мөн хэргийн газрыг хамгаалалтад авахдаа хамгаалалтын зориулалтын тууз, уяа, утас, шон, самбар зэрэг гарын доорх бусад материалыг ашиглах гэх мэт тодотгон оруулах.
	205.4.1 Шаардлагатай тохиолдолд иргэнийг сайн дурын үндсэн дээр хэргийн газрыг хамгаалахад...	Тухайн иргэний эрх ашгийг хамгаалсан заалт байхгүй.	Тухайн иргэнд эрх, үүргийг нь тайлбарлах талаар тусгаж өгөх.
4	<b>206. ХЭРГИЙН ГАЗРЫН ҮЗЛЭГ ХИЙХ</b>		
	206.4.10 Насанд хүрээгүй хүн, хэлгүй, дүлий, сэтгэц, мэдрэлийн илт мэдэгдэх өвчтэй хүн, эрүүгийн хэрэгт холбогдон шалгагдаж буй этгээд зэргийг хөндлөнгийн гэрчээр оролцуулахгүй.	1. Хэлгүй дүлий гэж хөгжлийн бэрхшээлээр ялгаварлажээ. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хүндэтгэх, хангах, хамгаалах үүргийг ЗГ, яамд, холбогдох агентлагууд хүлээдэг тул “Хэлгүй, дүлий” гэх хэллэгийг эерэг хандлагад нийцүүлэх.	.. хуульд заасны дагуу гэж зааж өгөх нь зүйтэй юм. Мөн “хэл, сонсголын бэрхшээлтэй” гэж нэр томъёог өөрчлөх. Тэдний гэрчээр оролцох эрхийг хязгаарласан нь хүний эрхийн зөрчил байна.

№	Журмын холбогдох заалт	Асуудал, дүгнэлт	Зөвлөмж
	206.4.3 ...албадан гаргана 206.4.24 ...үзлэг хийнэ 206.4.25 ...хураан авах битүүмжлэх, хадгална.. 206.4.26 ...хэв загвар, дээж авна	Холбогдох хууль, журмыг тус бүрд нь зааж, эрх зөрчигдөхгүй байх нөхцөлийг бүрдүүлэх.	
5	<b>210. ХҮН БАРЬЦААЛСАН ГЭМТ ХЭРГИЙГ ТАСЛАН ЗОГСООХ</b>		
	210.6 Биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх: Барьцаанд байгаа ...	Биеийн хүч, галт зэвсэг хэрэглэх бол “proportionality” зарчмыг баримтлах нь зүйтэй.	ЦАТХуулийн 48, 49 дүгээр зүйл болон ХЗДХС, УЕП-оос баталсан зааварт нийцүүлэн утгын алдааг засах. Холбогдох журмыг зааж өгөх.
6	<b>214. БИЧИГ БАРИМТЫГ ҮЗЭЖ ШАЛГАХ</b>		
	214.1 ...гэмт хэрэг, зөрчил үйлдэж байгаа болон үйлдсэн тухай ...	Хуульд нэг бүрчлэн заасан тул журамд эшлэхэд болох.	ЦАТХ-ийн 25-р зүйлд байгаа үндэслэл бүхий тохиолдолд гэж засах.
	214.3.2 ...түр саатуулж болно.	Хуулийг эшлэх, хүрээ хэт өргөн байна.	Тиймээс ЦАТХ- ийн 26-г үндэслэн түр саатуулахдаа 25-р зүйлийн зохих тохиолдлыг дурдаж, тухайн үндэслэл бүхий тохиолдолд түр саатуулахаар заах.
	214.1 ...үндэслэлтэй сэжиг..., 214.4.8... сэжиглэл байгаа...	Хуульд нэр томьёо өгсөн тул нэг мөр баримтлах.	ЦАТХ-д заасан “үндэслэл бүхий сэжиг” гэснээр журамд зааж өгөх.
	214.4.10 Монгол хэл мэддэггүй, насанд хүрээгүй, хэлгүй, дүлий, хараагүй, сэтгэцийн өвчтэй ...	“Хэлгүй, дүлий, хараагүй, сэтгэцийн өвчтэй” гэсэн нь хөгж- лийн бэрхшээлтэй хүнийг гадуурхсан шинжтэй байна.	“Хараа, сонсгол, оюуны бэрхшээлтэй хүн” гэж өөрчлөх.

№	Журмын холбогдох заалт	Асуудал, дүгнэлт	Зөвлөмж
	214.6 Хүний бичиг баримтад үзлэг хийхэд анхаарах зүйлс	Дур зоргоор авирлахаас сэргийлэх.	Зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг тусгасан хуулийг эшлэх.
7	<b>215. ХҮНИЙ БИЕ, ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ, АЧАА ТЭЭШИД ҮЗЛЭГ ХИЙХ</b>		
		Тус журам нь тусгай хуулиудаар зохицуулагдсан харилцааг хэт хуулбарласан, зарим талаар гажуудуулсан байна.	Хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэн батлах, ингэхдээ үзлэг хийж байгаа цагдаагийн алба хаагчийн баримтлах үйл ажиллагааны дэс дараалалд анхаарал хандуулах.
	215.1	Хүний биед үзлэг хийх үндэслэл гагцхүү хуульд байх ёстой.	Хүний бие, тээврийн хэрэгсэл, ачаа тээшид үзлэг хийх хууль зүйн үндэслэлийг тодорхой заах.
	215.5.1 в/... Мэргэжилтний туслалцаа авах боломжгүй тохиолдолд ижил хүйсийн алба хаагч үзлэг хийж болно.	“ижил хүйсийн албан тушаалтнаар хийлгэх тухай ЭХХШтХуулийн 23.2 дахь хэсэгтэй зөрчилдөж байна.	ЭХХШтХ-д нийцүүлэн өөрчлөх.
	215.7 Хүний биед үзлэг хийх эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа	215.7.8, 215.7.9 тухайн зүйлийн гарчигтай нийцэхгүй ачаа, тээшид хийх үзлэг орж ирсэн.	Журмын зорилгод нийцүүлэн өөрчлөлт оруулах.
	215.8.3 “тэмдэглэлд тусгаж болно”	Найруулгын шинжтэй засвар оруулах.	“хийж” гэснийг “хийсэн бол” гэж, “тусгаж болно” гэснийг “тусгана” гэх.

№	Журмын холбогдох заалт	Асуудал, дүгнэлт	Зөвлөмж
	215.9.1 Үзлэг хийхэд анхаарах зүйл	Тухайлбал, үзлэг хийх зорилгоос илүүтэй үндэслэл тун чухал бөгөөд дараа нь иргэн тухайн үндэслэлтэй санал нийлэхгүй бол гомдол гаргах үндэслэл болно.	Цагдаагийн хийвэл зохих үйлдэл, үг хэллэгийг тодорхой заах, хийж болохгүй үйлдлийг мөн тодорхой тусгах.
8	<b>217. ЭД ЗҮЙЛ, ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ, БАРИМТ БИЧИГ ТҮР ХУРААН АВАХ</b>		
	217.3.1 Цагдаагийн албаны тухай хуулийн 30 дугаар зүйлийг баримтлан дараах эд зүйл, баримт бичгийг цагдаагийн алба хаагч түр хураан авна:	Кодын гарчигт ялгаатай томьёолсон зүйлээ, дотор нь нэгтгэж тайлбарласан, хуулиас давсан буюу иргэний нэхэмжлэлийг хангах эд зүйл хураан авахаар заасан, хуульд байхгүй нэршлийг оруулж ирсэн (гүйлгээнд оруулахыг хориглосон эд юмс, баримт бичиг), хуулийг хуулбарласан.	Хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэн боловсруулж батлах, энэ үйлдлийг хийхдээ ЦАХ-ын гүйцэтгэвлэл зохих үйл ажиллагааны дэс дарааллыг тусгаж өгөх.
9	<b>218. ИРГЭН, АЛБАН ТУШААЛТНААС ТАЙЛБАР АВАХ, ГАРГУУЛАХ</b>		
		Эрхийг нь тайлбарлах заалт дутуу.	Эрх, үүргийг тайлбарлах заалтыг тодорхой тусгах.



№	Журмын холбогдох заалт	Асуудал, дүгнэлт	Зөвлөмж
10	<p>219. ШИНЖИЛГЭЭНД ЗОРИУЛЖ ДЭЭЖ, ДАРДАС, ХЭВ ХЭЛБЭР, ЗАГВАР АВАХ</p>	<p>Хуульд “хэв загвар, дээж” гэж байгаа бол “дээж, хэв хэлбэр, загвар, дардас” гэж ялгаатай нэрлэсэн, мөн “ул мөр” гэсэн нэр томъёо оруулж ирсэн.</p>	
	<p>219.3.12, 3.13 албадан авч болно.”</p>	<p>Хуульд өөрийн зөвшөөрлөөр эсхүл прокурорын зөвшөөрлөөр, авахаар байхад албадан авахаар заасан нь хүний эрх зөрчиж байна.</p>	<p>Хуульд нийцсэн байдлаар өөрчлөлт оруулах.</p>
	<p>219.3.15 Дээж, хэв, хэлбэр авах ажиллагааг шинжилгээний шаардлагад тохируулан ... шинжлэх ухаан, техникийн ололт, амжилтад түшиглэсэн арга, хэрэгслүүдийг ашиглахыг чухалчлах нь зүйтэй.</p>	<p>Хэрэглэж болох, зөвшөөрөгдсөн арга, хэрэгслийн нэр тодорхойгүй байна.</p>	<p>1. “олон улсын жишигт нийцсэн, шинжлэх ухаан, техникийн ололт, амжилтад түшиглэсэн арга, хэрэгслүүд” гэдгийг тодотгож, нэр зааж оруулах 2. “дээж, дардас, хэв, хэлбэр авахдаа тэдний зөвшөөрсний дагуу авах нь зохимжтойг анхаарах” гэсэн заалт нэмэх.</p>

№	Журмын холбогдох заалт	Асуудал, дүгнэлт	Зөвлөмж
11	<b>223. ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧИЛ ҮЙЛДСЭН ХҮНИЙГ БАРИВЧЛАХ, ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАД ХҮРГЭХ</b>		
	223.1 Зорилго	ЭХХШТХ-д нийцсэн зорилгоор гэсэн санааг нэмж тусгах.	Халдашгүй байх эрхэд халдаж буй үйлдэл тул хуулийн зорилгыг дурдах нь зүйтэй.
	223.2 Хамрах хүрээ	зөрчлийн хэрэгт баривчлах үйл ажиллагаа хийхгүй.	Хуульд нийцүүлэх.
	223.2.2 Цагдаагийн алба хаагчийн өдөр тутмын үйл ажиллагааны ...	Яг юу гэж зөвлөн зааварлах гэсэн нь ойлгомжгүй өгүүлбэр байна.	“...онцгой анхаарал тавих асуудал тул өөрийгөө хамгаалах, хүч хэрэгслийн тодорхой төрөл (гав зэрэг хүний хөдөлгөөнийг хязгаарлах)-ийг ашиглах ур чадвараа байнга хөгжүүлнэ” гэх маягаар энэ 2 заалтыг нэгтгэн засах.
	223.2.3 Тухайн нөхцөл байдалд...		
	223.8.5 Эрхийг тайлбарлах	Эрхийг тайлбарлах эсэх нөхцөл заажээ.	ЭХХШТХ-д тодорхой заасан байх тул үүнд нийцүүлсэн байдлаар томьёолох.
	223.9 Нэгжлэг хийх	Эсрэг хүйсийн хүний хяналтад нэгжлэг хийхээр байгаа нь ЭХХШТХ-тай зөрчилдөж байна.	
	223.10 Баривчлах ажиллагаатай холбогдуулан явуулах хяналт, шалгалт	Баривчлах, төрийн байгууллагад хүргэх, хуяглан хүргэх хэмээн ялгаатай үйлдлийг ялгаж зохицуулах шаардлагатай.	Журмыг хуульд нийцүүлэн шинэчлэн найруулах.

№	Журмын холбогдох заалт	Асуудал, дүгнэлт	Зөвлөмж
12	<b>224. ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ УРСГАЛ, ЧИГЛЭЛИЙГ ТҮР ӨӨРЧЛӨХ, ХААХ</b>		
	224.5.1 Цагдаагийн байгууллагаас...	Иргэдийг мэдээллээр хангах асуудал орхигджээ.	Шаардлагатай мэдээллээр хангуулах эрхийг нь хангах талаар заалт нэмэх.
13	<b>225. ТҮР СААТУУЛАХ</b>		
	225.5 Түр саатуулах байранд хүлээн авах	Насанд хүрээгүй хүн түр саатуулагдсан тохиолдолд ар гэрт нь мэдэгдсэн эсэхэд хяналт тавих заалт байхгүй.	“Насанд хүрээгүй хүний хувьд ар гэрт нь мэдэгдэх, эсхүл мэдэгдсэн эсэхэд хяналт тавих” талаар заалт оруулах.
	225.2 Нэр томьёо	Хуульд заасан зүйлийг давхардуулан тайлбарласан.	Давхардсан заалтыг эшлэх.
Хүний халдашгүй байх эрхэд халдаж байгаа тул хуульд нийцүүлэн журмыг шинэчлэн найруулах, хавсралтыг мөн эргэж харах.			
14	<b>230. ХУЛГАЙЛАГДСАН БОЛОН СУРАГГҮЙ АЛГА БОЛСОН ХҮНИЙГ ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛЭЭР ЗАРЛАХ</b>		
	230.2 Олон нийтэд мэдээлэх тохиолдол	230.2-ын а/-д гэр бүлийн маргаанаар алга болсон тохиолдолд зарлахгүй байхаар заасан нь хүрээг хязгаарласан байна.	Засах.

№	Журмын холбогдох заалт	Асуудал, дүгнэлт	Зөвлөмж
15	<b>232. ГЭМТ ХЭРЭГ ЗӨРЧИЛД ХОЛБОГДСОН ГАДААДЫН ИРГЭНТЭЙ ХАРИЛЦАХ</b>		
	232.10.1 Цагдаагийн алба хаагч ... мөрдөн шалгах ажиллагаа, зөрчлийг хянан шийдвэрлэх ...	ЦБҮАЖ-ын дагуу мөрдөн шалгах ажиллагаа, зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулна гэсэн нь ойлгомжгүй байна.	Харин ЦБҮАЖ-д заасны дагуу үйл ажиллагаагаа хэрэгжүүлнэ гэх зэргээр найруулгыг засах.
	232.2 “МЦ-ын иргэний давхар харьяалалтай...”	Давхар харьяалал зөвшөөрдөггүй.	Эрхийг сануулах үүргийг бүрэн тусгаж өгөх, хуульд нийцүүлэн нэмэлт, өөрчлөлт оруулах.
	232.10 Дипломат эрхгүй гадаадын иргэн	Эрхийг сануулах үүрэг бүрэн тусаагүй.  Харьяалалгүй хүнийг хэрхэх нь орхигджээ.	
16	<b>238. ХЭЛНИЙ БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНД ТУСЛАХ</b>		
	238.2 Нэр томьёо: Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно: “Хэлний бэрхшээлтэй хүн” - ...	ЭХХШтХ-иар зохицуулагдах харилцааг эшлэн оруулах нь зүйтэй. Мөн “хэлгүй, дүлий” зэрэг нэр томьёог эргэж харах.	ЦАХ гэмт хэрэгтэй тэмцэхээс бусад тохиолдолд хэлний бэрхшээлтэй хүмүүстэй хэрхэн харилцахыг нарийвчлан журамлаж, харин гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийг ЭХХШтХ-иар зохицуулсан тул эшлэн орхих нь зүйтэй.

№	Журмын холбогдох заалт	Асуудал, дүгнэлт	Зөвлөмж
17	<b>242. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН БАЙГУУЛЛАГАТАЙ ХАРИЛЦАХ</b>		
	Гэрч, хохирогчийн тухай мэдээлэхдээ Гэрч, хохирогчийн хамгаалах тухай болон ЭХХШтХ-д нийцүүлэх тухай заалт оруулах.		
	242.2.7 Хувь хүний нууцын тухай хуулийн 4 дүгээр зүйлд ...	Тус хуулийн 4 дүгээр зүйлд заасан тодорхойлолтыг эш татжээ.	Хуулийн заалтыг шууд эш татан тодорхойлолтыг дахин зохицуулан заах бус тайлбарлан оруулах.
242.3.2 ...хүчирхийлэл, аллага хядлага, садар самуун...	Энэ заалт 242.5-тай давхцаж байна.	Засах.	
18	<b>302. ГЭМТ ХЭРЭГ ИЛРҮҮЛЭХ АЖИЛЛАГААНД ПОЛИГРАФ АШИГЛАХ</b>		
	302.3.1 Полиграфын тоног төхөөрөмж нь ...	Оролцогчид эрхийг сануулах, гагцхүү сайн дурын үндсэн дээр байх зарчмыг тодорхой тусгаагүй.	Энэ талаар журамд тусгаж өгөх.
19	<b>309. СОНГУУЛЬД НЭР ДЭВШИГЧИЙГ ЭРҮҮГИЙН ХЭРЭГТ ШАЛГАХ ЗӨВШӨӨРӨЛ ХҮСЭХ</b>		
	309.3.3 Сонгуулийн тойрог, салбар, хэсгийн хорооны байрыг цагдаагийн эргүүлийн чиглэлд хамруулах замаар хяналтад авах, ... ойлгож мэдсэн байх шаардлагатай.	Журмын нэр болон эрүүгийн хэрэгт шалгахад зөвшөөрөл хүсэхтэй холбоогүй заалт байна.	Тухайн асуудалд хамааралгүй зүйлүүд тусгасныг хасах, нэр дэвшигчийг эрүүгийн хэрэгт татахад баримтлах үйл ажиллагааны дэс дараалал, баримтлах зарчим, стандартыг тусгасан байдлаар системтэй боловсруулах.

№	Журмын холбогдох заалт	Асуудал, дүгнэлт	Зөвлөмж
20	<b>311. МАНСУУРУУЛАХ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨЛӨХ БОДИСТОЙ ХОЛБООТОЙ ХЭРГИЙГ ШАЛГАХ</b>		
	311.3.7 ...гэр бүлийн гишүүн эсэхийг тогтоож...	Тогтоосон бол ЭХХШТХ-ийн 9.6.5-ыг сануулах тухай орхигдуулсан.	Зөрчлийг, гэмт хэргээс салгах асуудал орхигдсон. Тиймээс үйл ажиллагааны дэс дарааллыг эргэж нягталж сайжруулах.
21	<b>312. БАРИВЧЛАГДСАН, ЦАГДАН ХОРИГДСОН ЭТГЭЭДИЙГ ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦУУЛАХ</b>		
	312.4.2 ...үзлэг	Тухайн байгууллагаас авч гарж байгаа бол заавал нүцгэн биеийн үзлэг хийж, хүлээлцэх ёстой.	Тухайн газраас гаргаж, хүлээлгэж өгөх тухай бүрд энэ зүйлийг хийх шаардлагатай бөгөөд нөгөө талаас алба хаагчийг хамгаалах хамгаалалт болох учиртай.
	312.4.5 Хэд хэдэн хоригдсон этгээдийг...	“Хэд хэдэн этгээд” гэх нэр томъёо ойлгомжгүй байдлыг бий болгож байна.	2 (3) ба түүнээс дээш этгээд гэх мэт томъёолох.
	312.4.8 Хоригдсон этгээдийг оролцуулах ...урьдчилан мэдэгдэх эсэхийг алба хаагч өөрөө шийдвэрлэнэ.	Заавал мэдэгдэх тохиолдлуудыг тусгах, Холбогдох бусад хууль, гэрч, хохирогчийн эрх зэрэгтэй нягталж үзэх хэрэгтэй.	... этгээдэд заавал мэдэгдэх талаар тодотгол оруулах.

№	Журмын холбогдох заалт	Асуудал, дүгнэлт	Зөвлөмж
22	<b>316. ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАНГАХ</b>		
	316.3.2 Тухайн хүүхдийг хаана, ямар байдалтай ... мэдээллээр хангана.	Хугацаа	Хуулийг эш татан оруулах.
	316.3.6 Баривчлах, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан хүүхдийг мөрдөн шалгах тодорхой ажиллагаа явуулахад 4-өөс илүү цаг зарцуулахаар бол түүнийг хооллуулах арга хэмжээг авна.	Хаана, хэн хооллуулах нь тодорхойгүйгээс практикт биелэгдэхгүй (алба хаагч хувиасаа гаргах) байхад хүргэх.	Тухайн шаардлагатай тохиолдолд уг зардлыг хэрхэн гаргах, хаана, хэрхэн хооллуулах, эсхүл алба хаагчийн ... баримт материалыг үндэслэн гаргасан зардлыг нөхөн авах г.м. асуудлын талаар нарийвчилсан зохицуулалт оруулах. Жишээ нь: цайны газартай гэрээ байгуулах юм уу, алба хаагч хувиасаа гаргаад дараа нь нөхөн авах.
	316.3.7 Хүүхдийг баривчлах, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авахаар бол нүцгэн биеийн үзлэгийг хийж, тэмдэглэлийг хавсаргана.	Хүүхэд эрх зүйн бүрэн чадамжгүй, ичимхий, бүрэг байдлаас сэтгэл санааны болон бусад хохирол амсах магадлал их байдаг тул нүцгэн биеийн үзлэг хийхдээ болгоомжтой хандах хэрэгтэй.	Тухайлбал: Ингэхдээ ЭХХШТХуулийн 23.2 болон энэхүү журам (код 215)-ын 215.7.5-7-д заасныг тус тус баримтална” гэж нэмэлт оруулах.

№	Журмын холбогдох заалт	Асуудал, дүгнэлт	Зөвлөмж
	316.3.16 Хэрэв хүүхэд согтууруулах болон мансууруулах төрлийн зүйл хэрэглэсэн...	Архидан согтуурал ба мансуурал нь өөр өөр асуудал ба ялгаатай эмчилгээг шаардана.	Иймд энэ хэсэгт “эрүүлжүүлэх болон мансуурлаас гаргах шаардлагатай эмнэлгийн арга хэмжээ авах” талаар нэмэлт өөрчлөлт оруулах.
	316.3.17 Сэтгэцийн хувьд хэрэг хариуцах чадвартай эсэхийг тогтоолгох, эсхүл оюун ухаан нь гүйцэд хөгжсөн эсэх талаар дүгнэлт гаргуулахаар шинжилгээ хийлгэнэ.	Тухайн алба хаагчийн мэргэжлийн ур чадвараас шалтгаалан сэтгэцийн хувьд өөрчлөлттэй (хоцрогдолтой) хүүхдийг таньж мэдэхгүй өнгөрөх, Бээжингийн дүрмийн гол зарчим хэрэгжихгүй байх, цаашлаад эрүүгийн хариуцлага хилсээр хүлээх эрсдэлийг дагуулах тул мэргэжилтний туслалцааг авах асуудал чухал.	"Сэтгэцийн хувьд асуудалтай, оюун ухаан нь гүйцэд хөгжөөгүй байж болох шинж тэмдэг илэрсэн тохиолдолд сурган хүмүүжүүлэгч, сэтгэл зүйчийн туслалцааг заавал авна" гэсэн нэмэлт оруулах.
	316.4 Насанд хүрээгүй хүүхдийн эрхийг хангах зорилгоор тусгай өрөө ашиглах	Энэ өрөөнд маш олон төрлийн үйл ажиллагаа байнга тасралтгүй явагдаж байх ёстой бөгөөд хүүхдийн асуудал хариуцсан ганцхан алба хаагч өөрийн бусад ажлын хажуугаар тэдгээрийг зохион байгуулах, явуулах боломжгүй, хүүхдийн эрх зөрчигдсөөр байгаа.	“Хүүхэд хамгааллын өрөө”-г хариуцан ажиллах тусгай алба хаагчийг орон тоогоор ажиллуулах асуудал.



№	Журмын холбогдох заалт	Асуудал, дүгнэлт	Зөвлөмж
	Нэмэлт оруулах	<p>Насанд хүрээгүй этгээдийн хувийн байдал, эрх зүйн зөрчлийн шалтгаан (сэдэл, хандлага) нь дахин гэмт хэрэгт холбогдохоос сэргийлэх, засарч хүмүүжих боломж олгох, хэрэгт хамтран оролцогч, уруу татагчийн зүгээс үзүүлэх дарамт, шахалтаас хамгаалах, хүлээлгэх ял шийтгэлийг ононвчтой тодорхойлох нь маш чухал, сайтар нягтлан судлах хэрэгтэй байдаг. Насанд хүрээгүй этгээд (гэмт хэрэг үйлдсэн, гэрч, хохирогч)-ийн эрх, ашиг сонирхлыг дээд зэргээр хамгаалсан зохицуулалт дутмаг байна.</p>	<p>1. Гэр бүл дэх амьдралын нөхцөл, хүмүүжлийн байдлыг судлах                  2. Сэтгэл зүйч, сурган хүмүүжүүлэгч оролцуулахдаа хүүхдийг сайн мэддэг, нарийн мэргэшсэн мэргэжилтнийг урьж оролцуулахыг урьдач болгох                  3. Хүүхдийг эцэг, эх асран хамгаалагч нарын зүгээс уруу татан гэмт хэрэгт оролцуулсан бол мэдүүлэг байцаалт авахдаа хүүхдийн асуудал эрхэлсэн байгууллагын зохих албан тушаалтныг хууль ёсны төлөөлөгчөөр оролцуулах                  4. Уруу татагдан гэмт хэрэг үйлдсэн бол “насанд хүрээгүй хохирогч”-ийн эрхийг нь эдлүүлэх буюу хохирогчоор давхар тогтоох                  5. аудио, видео бичлэгээр баримтжуулах, ярилцлага хэлбэрээр мэдүүлэг авах гэх мэт тактик ажиллагаануудыг зааварчилга хэлбэрээр оруулах.</p>

№	Журмын холбогдох заалт	Асуудал, дүгнэлт	Зөвлөмж
23	<b>317. БЭЛЭГСИЙН ГЭМТ ХЭРГИЙН НАСАНД ХҮРЭЭГҮЙ ХОХИРОГЧИЙН ТАЛААР АВАХ АРГА ХЭМЖЭЭ</b>		
	317.4 Хохирогчтой харилцах. в/эмзэг хохирогч хүүхэдтэй харьцахдаа тусгай өрөөнд орж уулзахыг эрмэлзэх	Аль болох тусгай мэргэжилтэн оролцуулах. Сэтгэл зүйчийг оролцуулснаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны туршид насанд хүрээгүй хүнд ерөнхий сэтгэл зүйн болон сэтгэл зүйн дэмжлэгийг үзүүлэх, цаашид авах арга хэмжээ (сэтгэл зүйн өөрчлөлттэй болсон буюу айж цочдог, орондоо бие засдаг, хичээл сурлагадаа муудах, буруу замд орох)-г зөв тодорхойлон хэрэгжүүлэх, цаашлаад мөрдөн шалгах ажиллагаанд эерэг үр дүн авчрах юм.	“эрмэлзэх” гэдгийг хасаж “уулзана” гэж өөрчлөх. Учир нь бүх нэгж газарт хүүхдийн тусгай өрөө байгуулах нь зүйтэй, харин тийм өрөө байхгүй тохиолдолд аль болох ганцаарчилсан байдлаар уулзалтыг зохион байгуулна гэх. Мөн хэрэв уг гэмт хэрэг үйлдсэн этгээд нь эцэг, эх, төрөл садангийн хүн бол тэдгээрийг байлцуулахаас татгалзаж, хүүхдийн байгууллагын ажилтныг хууль ёсны төлөөлөгчөөр оролцуулах, сурган хүмүүжүүлэгч, сэтгэл зүйчийг байлцуулж болно” гэж нэмэх.
24	<b>326. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ</b>		
	д/ хүчирхийллийн хохирогчид өмгөөлөгч авч эрхээ ...	Ялгаварлан гадуурхлын шинж агуулсан.	Өмгөөлөгч авах эрхийг нь хохирогч болон сэжигтэн аль алинд нь олгох.
	ж/ шаардлагатай гэж үзсэн ...	Шаардлагатай гэдэг нь тодорхойгүй байдал бий болгож байна.	Тодотгох.

№	Журмын холбогдох заалт	Асуудал, дүгнэлт	Зөвлөмж
	о/ ...захиргааны журмаар баривчлах шийтгэл ...	Захиргааны журмаар баривчлах шийтгэл гэж байхгүй.	Захиргааны журмаар гэдгийг хасах.
	326.8.4 ..хойшлуулшгүй ажиллагааг ...	Хойшлуулшгүй ажиллагаа гэсэн нэр томъёо байхгүй.	Өөрчлөх.
	326.8.9 Энэ журмын биелэлтэд Цагдаагийн төв байгууллагын ...	Субъект нь тодорхой бус байна.	Тодотгох.
25	<b>503. ЖАГСААЛ, ЦУГЛААНЫГ АЛБАДАН ТАРААХ</b>		
	503.4.1 Дараах тохиолдолд Засаг дарга жагсаал цуглааныг албадан тараах тухай ...	Хуулиас давсан зохицуулалтыг бий болгосон эсэх.	Жагсаал цуглааныг албадан тараах тохиолдлуудыг хичээл зааж байгаа мэт оруулсан байгааг өөрчилж, хуулийн заалтыг эш татах.
	503.5 Анхаарах зүйл	Анхаарах зүйлийн хүрээнд хүнийг эрхийг хангаж ажиллахыг анхааруулсан заалт байхгүй.	Нэмж тусгах.
26	<b>505. ОНЦ БАЙДАЛ ЗАРЛАСАН ҮЕД НИЙТИЙН ХЭВ ЖУРАМ ХАМГААЛАХ, ОЛОН НИЙТИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ</b>		
	505.2.1 ...	Үндсэн хуулийн заалтыг эш татах.	Үндсэн хуулийн заалтыг эш татах.
	505.2.2 Онц байдал зарласан шийдвэр ... хэлбэрэлтгүй хэрэгжүүлж ажиллана.	Хүч нэмсэн үг хэрэглэхээс татгалзах.	“Хэлбэрэлтгүй”-г хасах.

№	Журмын холбогдох заалт	Асуудал, дүгнэлт	Зөвлөмж
	505.2.3 Цагдаагийн байгууллага, алба хаагч нь ...	Цагдаагийн байгууллага, алба хаагч нь хүний эрх, эрх чөлөөг хязгаарлахдаа хуульд заасан үндэслэл журмын дагуу л хязгаарлана.	“хуульд заасан үндэслэл журмын дагуу” гэж нэмэх, Үндсэн хуулийн заалтыг эшлэх
27	<b>511. ГЭРЧ, ХОХИРОГЧИЙГ ХАМГААЛАХ</b>		
	511.2 Нэр томьёо	Хуульд заасан нэр томьёог шууд хэрэглэсэн байна.	Эш татаж хэрэглэх.
	511.4 Гэрч, хохирогчийн аюулгүй байдал ба хувийн нууцыг хадгалах: в/ шаардлагатай тохиолдолд хохирогч, гэрч болон түүний гэр бүлийн гишүүд, өмч хөрөнгийг хамгаалалтад авах	Шаардлагатай тохиолдолд гэдэгт ямар нөхцөл байдлыг ойлгох вэ?	Журамд заасан үндэслэл байгаа тохиолдолд гэж заах.
		Өмч хөрөнгийг хамгаалах гэсэн нь маргаан үүсгэх магадлалтай байна. Учир нь гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой асуудалд тухайлбал, гэр бүлийн дундын хөрөнгийг хэрхэн хамгаалах вэ? Энд хүссэн эд хөрөнгөө цагдаагийн байгууллагаар далимдуулан авах хүсэлт гаргах асуудал гарч болзошгүй, гэр бүлийн асуудал, маргаан дагуулна.	Тухайн гэрч, хохирогчийн ойр зуурын хэрэгцээг хангах, шаардлагатай эд зүйлсийг болон шүүхийн шийдвэрээр эд хөрөнгийг хамгаалах гэх зэргээр ойлгомжгүй зүйлийг тодотгон тусгах нь зүйтэй болов уу.

№	Журмын холбогдох заалт	Асуудал, дүгнэлт	Зөвлөмж
	511.3.1 г/	Хохирогч эрэгтэй байж ч болохыг тооцоогүй.	“ижил хүйсийн” гэх.
	511.6.6 Хяналтын хэрэгтэй танилцах	Гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалахад аль болох цөөн хүн мэдээлэлд нэвтрэх эрхтэй байх ёстой ч хэт олон хүн нэвтрэхээр байна.	Мэдээлэлд нэвтрэх орох этгээдийг хязгаарлах.
	Гэрээний 3-т: хамгаалуулагчийн эрх, үүрэг	Зөвхөн үүргийг заасан.	Эрхийн талаар нэмж дурдах.
	Нэг бүрийн тусгай хэрэгслээр.... Хангагдах.. Гэрээ	Хамгаалуулагчийг нэг бүрийн тусгай хэрэгслээр хангахаар заасан ч ашиглаж чадахгүй тохиолдолд өөрийгөө болон бусдыг эрсдэлд оруулж болзошгүй.	Тусгай сургалтад хамруулах үүргийг хамгаалагч талд нэмж тусгах.
28	<b>604. АЛБАДАН НҮҮЛГЭХ ТУХАЙ ЗАСАГ ДАРГЫН ШИЙДВЭРИЙГ БИЕЛҮҮЛЭХИЙГ ЭСЭРГҮҮЦСЭН БОЛ АРГА ХЭМЖЭЭ АВАХ</b>		
	Журам бүхэлдээ	Хүний эрхийг зөрчсөн заалт байхгүй ч эрхийн хамгаалалтыг илүү сайн тусгаж өгөх шаардлагатай, нэр томъёог эш татаж хэрэглэх.	“Албадан нүүлгэх ажиллагаанд оролцохдоо хүний эрх, эрх чөлөөг дээдэлж, хуульд заасан үндэслэл журмын дагуу явуулна” гэсэн заалтыг нэмэх.

№	Журмын холбогдох заалт	Асуудал, дүгнэлт	Зөвлөмж
	604.8 Биеийн...	Тус журам нь алба хаагчийн тухайн үед баримтлах гол зохицуулалт тул хамааралтай бусад кодыг эшлэн дурдах шаардлагатай.	Хэрэглэх хууль тогтоомж, кодыг нэрлэх.
29	<b>608. ЗАРИМ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН БИЕЛЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ</b>		
	608.6.1 Интернет кафе болон цахим тоглоомын үйлчилгээ эрхлэх талаар ...	Хууль зүйн үндэслэлийг заагаагүй байна. Өөрөөр хэлбэл, журмаар хариуцлага хүлээлгэхээр ойлгогдож байна.	Тодорхой болгох.
30	<b>611. ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ ТАЛААР ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ</b>		
	611.1 Зорилго: Цагдаагийн байгууллагын хөдөлгөөний ...	Иргэд, хуулийн этгээдэд урьдчилан анхааруулж, мэдэгдэх, санал авах харилцааг нарийвчлан тусгаж өгөөгүй байна.	Энэ талаар тусгаж өгөх.

№	Журмын холбогдох заалт	Асуудал, дүгнэлт	Зөвлөмж
31	<p><b>626. ГАДААДЫН ИРГЭНИЙГ МОНГОЛ УЛСААС АЛБАДАН ГАРГАХАД ОРОЛЦОХ</b></p> <p>Журам 626.</p>	<p>Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргахад цагдаагийн байгууллагаас хуульд заасан үндэслэл, журмын дагуу оролцохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</p>	<p>Хууль зүйн үндэслэлийг тодорхой болгох, эрүүдэн шүүгдэх бодитой үндэслэл байвал албадан гаргахгүй байх үүргийг тусгаж өгөх.</p>
32	<p><b>627. СОНГУУЛЬД НЭР ДЭВШ ИГЧИЙН ТАЛААР ЛАВЛАГАА ОЛГОХ</b></p> <p>627.4 Ял шийтгэлтэй...</p>	<p>Ял шийтгэлтэйд тооцох хугацаа гэсэн ойлголт байхгүй болсон байхад сонгогдох эрхийг хязгаарласан.</p>	<p>Хуульд нийцүүлэн өөрчлөн найруулах.</p>

3.3. Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжид нийцээгүй, эсхүл тодорхой үйл ажиллагааг нарийвчлан тогтоох шаардлагатай журмууд

Хүснэгт 5.

№	Журмын холбогдох заалт	Асуудал, дүгнэлт	Зөвлөмж
1	<b>200. ШУУРХАЙ УДИРДЛАГЫН АЛБАНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА</b>		
	200.4.3 Мэдээллийн менежерийн үүрэг	Уг хандалтыг хэрхэн ямар аргаар лавлах, хуурамч дуудлага, мэдээлэл өгсөн тохиолдолд ямар арга хэмжээ авах эсэх нь тодорхойгүй.	Утсан холбоо буюу мэдээлэл ирүүлсэн сувгаар эргэж холбогдох боломжгүй, сэжиг бүхий тохиолдолд харьяа нутаг дэвсгэрийн ЦБ-ын хэсгийн байцаагч, цагдаа эсхүл ойролцоо үүрэг гүйцэтгэж буй эргүүлийн алба хаагчид, орон нутагт бол хэрхэн, ямар хугацаанд шалгуулах, цугларсан мэдээллийг ахлах зохицуулагчид шуурхай танилцуулах, ASAP санд мэдээлэл оруулах талаар тодотгосон заалт нэмэх.
	в/ амжилтгүй болсон хандалтыг лавлах, хуурамч дуудлагын дүнг гаргах	Амжилтгүй болсон хандалтыг лавлах /хаяг байршлыг зөв тогтоох, хэрхэн шуурхай арга хэмжээ авах эсэх асуудлыг тодотгох	
	Хуурамч дуудлага, мэдээлэл өгсөн тохиолдолд Эрүүгийн цагдаагийн албанд хүргүүлэхээр заасан ч цааш хэрхэх нь журамд тусаагүй.		
2	<b>202. ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН ТАЛААРХ ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ</b>		
	202.3.1 ж/ гэмт хэрэг, зөрчлийн талаар гомдол мэдээллийг... хуульд заасан 5 хоногийн хугацаа хэтрэхээр бол...	Гэмт хэрэг, зөрчлийн гомдол мэдээллийг шалгаж шийдвэрлэх хугацаа өөр байдаг.	1. “хойшлуулшгүй ажиллагаа” гэсэн нэр томъёог өөрчлөх 2. гэмт хэрэг, зөрчлийг нэгтгэн заасан нь ЭХХШТ, ЗШШТХ-тай нийцэхгүй байна. Иймд “хуульд заасан” гэдгийг тодотгон ЭХХШТХ-д заасан 5 хоног, ЗШШТХ-д заасан 3 хоног гэж засах.



№	Журмын холбогдох заалт	Асуудал, дүгнэлт	Зөвлөмж
	<p>202.5 Харьяаллын дагуу ... 202.5.1 Гомдол, мэдээллийг цагдаагийн байгууллага, алба хаагч ажил үүргийн дагуу шалгаж шийдвэрлэнэ. 202.5.2 Хүлээн авсан гомдол, мэдээллийг нэн даруй ...</p>	<p>“Харьяаллын дагуу ... шилжүүлэх” гээд 202.5.1-д: “цагдаагийн алба хаагч ажил үүргийн дагуу шалгаж шийдвэрлэнэ” гэсэн заалт нь өөрийн дураар шийдвэрлэх бололцоог олгосон мэт харагдаж байна. Мөн “нэн даруй” гэсэн заалт мэдээлэл нэг бүрийг нэн даруй танилцуулах гэж ойлгогдохоор байна. Эрх бүхий алба хаагч хэн болох нь тодорхойгүй.</p>	<p>“Засан сайжруулах. 202.2.1-тэй уялдуулах, “эрх бүхий алба хаагч” гэдгийг нэрлэх.</p>
	<p>202.316 маягт, 7.1-д “...Эрүүгийн хуулийн 252 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэх талаар ...</p>	<p>Ихэнх тохиолдолд яг ямар хариуцлага хүлээхийг тодорхой хэлдэггүй тул хариуцлагыг задалж бичих.</p>	<p>Иргэний эрх хамгаалагдана.</p>
3	<p><b>204. ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧИЛД СЭРДЭГДСЭН ХҮНИЙГ ХҮЛЭЭН АВАХ</b></p> <p>204.3.1 г/ хойшлуулшгүй ажиллагаа явуулах; 204.3.3 ...хойшлуулшгүй ажиллагаа явуулах</p> <p>204.3.1 а/ шаардлагатай бол зохих журмын дагуу түр саатуулах</p>	<p>Нэр томёоны алдаа. “хойшлуулшгүй ажиллагаа” гэх нэр томьёог хуульд хэрэглэхээ больсон.</p> <p>“шаардлагатай бол” гэснийг тодруулах, зохих журмыг гэснийг журмын дугаарыг тавих.</p>	<p>Өөрчлөх.</p>

№	Журмын холбогдох заалт	Асуудал, дүгнэлт	Зөвлөмж
4	<b>207. ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛЫН ГАЗРЫГ ХАМГААЛАХ, ҮЗЛЭГ ХИЙХ</b>		
	207.6.5 Криминалистикийн шинжээч нь ... Хэрэв хохирогч болон холбогдогчийн цусанд шинжилгээ хийлгэх бол ...	Согтууруулах ундааны зүйл, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн эсэхийг тандах багаж, энгийн аргаар хэрхэн шалгах, түүнчлэн гэмт хэргийн шинжтэй, эхсүл тухайн этгээд шалгуулахаас татгалзсан тохиолдолд шүүх эмчийн дүгнэлт гаргуулах ажиллагааг уг журмаар нарийвчлан зохицуулсан.	“Хэрэв” гэсний оронд “Ингэхдээ” гэж өөрчлөх.
5	<b>208. АГААРЫН ХӨЛГИЙН ОСЛЫН ГАЗРЫГ ХАМГААЛАХ, ҮЗЛЭГ ХИЙХ</b>		
	208.8.3 Шаардлагатай тохиолдолд ...	“Шаардлагатай тохиолдолд” гэснийг илүү тодорхой зааж оруулах.	Журамд заасан нэр томъёонуудаас тохирохыг эш татаж хэрэглэх.
	208.9.1 ...в/осол, хэргийн талаар ...	Хэт ерөнхий заалт байна.	208.9.1 а хүрээнд мэдээлэх гэсэн байдлаар өөрчлөх.
6	<b>209. ОСОЛ, ГЭМТЛИЙН ҮЕД АНХАН ШАТНЫ ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭХ</b>		
	209.3.2 Осол, гэмтлийн газарт очсон цагдаагийн алба хаагч анхны тусламж үзүүлэх...	Дэс дарааллын хувьд хүмүүс гэмтсэн тохиолдолд хамгийн түрүүнд эмнэлгийн яаралтай түргэн тусламж дуудах явдал юм.	“209.3.2 в”-г “а” болгох
	209.3.6 Цагдаагийн алба хаагч эмнэлгийн яаралтай тусламж ирэх хүртэл шаардлагатай тохиолдолд өөртөө болон бусдад анхны тусламж ...	Амь насанд онцгой эрсдэлтэй, цус их хэмжээгээр алдах үеийн тусламжийг орхигдуулжээ.	Тусламж хэрхэн үзүүлэхийг биечлэн үзүүлсэн зурган тайлбар оруулах.
		Шинэчлэх.	Анхны тусламж үзүүлэх зааврыг шинэчлэх. ЦАХ хийх ёстой алхмыг, шаардлагагүй алхмаас салгаж, зааглах.

№	Журмын холбогдох заалт	Асуудал, дүгнэлт	Зөвлөмж
		Цагдаагийн албанд шинээр орсон хүнд заавал суралцах зүйл болохыг журамд тусгах.	
7	<p><b>211. ТЭСЭРЧ ДЭЛБЭРЭХ, ХИМИЙН ХОРТ БОЛОН ЦАЦРАГ ИДЭВХТ БОДИСЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ ХҮЛЭЭН АВЧ, АЖИЛЛАХ</b></p> <p>211.5.1 в/ хамгаалах хувцас өмсөх, газ эсэргүүцэгч, хүчилтөрөгчийн баг хэрэглэх, хэрэв баг байхгүй тохиолдолд нойтон алчуураар ам, хамраа дарах</p>	Цагдаагийн алба хаагчийн хувийн аюулгүй байдлыг эрсдэлд оруулсан заалт.	Холбогдох байгууллагуудаас гаргасан химийн хорт болон аюултай бодистой харьцах зааварчилгааг баримтлах, журамласан бус зөвлөмж маягаар оруулах, Нэр томьёог эш татаж хэрэглэх.
8	<p><b>213. ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙГ ШАЛГАХ ХОЙШЛУУЛШГҮЙ АЖИЛЛАГАА</b></p> <p>213.3.1 Хойшлуулшгүй ажиллагаа нь ЭХХШТухай, ЗШШТухай хуульд заасан төрөлтэй байна.</p> <p>213.3.2 Хойшлуулшгүй ажиллагааг ЭХХШТХ- ийг удирдлага болгон дараах журмаар гүйцэтгэнэ...</p>	ЭХХШТХ-д зарим ажиллагааг мөрдөгч прокурорын зөвшөөрлөөр хийхээр байхад энэ журмаар ЦАХ-аас хойшлуулшгүй ажиллагааны үед явуулахаар журамласан байна. Журмын 213.3.2, 213.3.3 заалтаас харахад 213.3.2-т “дараах журмаар гүйцэтгэнэ” гэсэн боловч журам бус үйл ажиллагааны төрөл хэлбэртэй жагсаалт байна.	ЭХХШТХ-д нийцүүлэн журмыг шинэчлэх.
9	<b>216. ЭД ЗҮЙЛ, ХӨРӨНГӨ, МӨНГӨ АГУУЛСАН БАЙР САВЫГ БИТҮҮМЖЛЭХ</b>		

№	Журмын холбогдох заалт	Асуудал, дүгнэлт	Зөвлөмж
	216. Эд зүйл, хөрөнгө, мөнгө агуулсан байр савыг битүүмжлэх	Цагдаагийн алба хаагч битүүмжлэх ажлыг хийхэд өмчийн эзэнтэй хэрхэн харьцахыг заагаагүй.	Хуулийг давхардуулахаас илүүтэй битүүмжлэх ажлыг гүйцэтгэа ЦАХ-ын хийх үйл ажиллагааны дэс дарааллыг тодорхой заах.
10	<b>220. СОГТУУРУУЛАХ УНДАА, МАНСУУРУУЛАХ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨЛӨХ, ХОРДУУЛАХ БОДИС ХЭРЭГЛЭСЭН ЭСЭХИЙГ ШАЛГАХ</b>		
	...бусад багаж хэрэгсэл...	Ямар багаж хэрэгсэл болох нь ойлгомжгүй байна.	ЦЕГ-ын даргын баталсан багаж, хэрэгслийн жагсаалтыг кодоод нэмж тусгах.
220.3.7	Согтууруулах ундаа, мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм, бодис хэрэглэсэн эсэхийг шалгагч багаж хэрэгслийг ашиглахдаа үйлдвэрлэгчээс ирүүлсэн зааврыг баримтална.	Уг зааврыг цагдаагийн алба хаагч мэдэхгүй тохиолдол гарч болно.	Энэ заалтын өмнө: “Согтууруулах ундаа, мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм, бодис хэрэглэсэн эсэхийг шалгагч багаж хэрэгслийн талаарх үйлдвэрлэгчээс ирүүлсэн зааврыг алба хаагч бүр сайтар мэдсэн байх бүх талын арга хэмжээг авах бөгөөд” гэсэн удирдлагад чиглэсэн заалт нэмэх.
220.4.4	Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн эсэхийг тандахдаа үнэрлэх эрхтний тусламжтайгаар мэдэрч болох боловч энэ арга нь алба хаагчийн эрүүл мэнд, амь насанд аюул, эрсдэлтэй тул аль болох татгалзах нь зүйтэй.	“...үнэрлэх эрхтний тусламжтайгаар мэдэрч болох боловч ...” гэсэн нь амьсгалын замаар халдварлах өвчин эмгэгтэй хүнээс алба хаагчийн амь нас, эрүүл мэндэд халдах аюул учруулах эрсдэлтэй заалт байна.	Уг заалтыг хасах.

№	Журмын холбогдох заалт	Асуудал, дүгнэлт	Зөвлөмж
		Уг журам нь бүтэц, зохион байгуулалтын хувьд дэс дараалал хангалтгүй байна.	Цагдаагийн алба хаагчийн хийвэл зохих үйлдлийн дэс дарааллыг нягт нямбай тусгаж өгөх.
11	<b>222. БАЙГУУЛЛАГА, ИРГЭНИЙ ОРОН БАЙРАНД НЭВТРЭН ОРОХ</b>		
	Журам бүхэлдээ	Логик, уялдаа муутай.	ЦАХ-ийн үйл ажиллагааны дэс дарааллыг цэгцтэй тусгах.
12	<b>226. КОМПЬЮТЕРИЙН БОЛОН ЦАХИМ ЭД МӨРИЙН БАРИМТЫГ ХУРААН АВАХ</b>		
	226.4.1 е/эвдэрч, гэмтэхээс урьдчилан сэргийлсэн зориулалтын битүүмжлэл бүхий хайрцаг, саванд хадгалах ёстой; 226.5. Холбооны хэрэгслийг хураан авах ...гар утсыг сүлжээ унагагч уут, саванд хийх;	“зориулалтын битүүмжлэл бүхий хайрцаг”, “сүлжээ унагагч уут, сав” гэдгийг тайлбарлах.	Ямар хайрцаг, уут, сав байх, хаанаас хэрхэн авахыг тодотгох.
13	<b>233. ТУСГАЙ ДУУТ БОЛОН ГЭРЛЭН ДОХИО ХЭРЭГЛЭХ</b>		
	233.3.4 Хойшлуулшгүй албан үүрэг гүйцэтгэхээс бусад үед ...дүрмийн дагуу хөдөлгөөнд оролцох ёстой.	Хойшлуулшгүй албан үүрэг гүйцэтгэх гэдэг заалтыг нарийвчлах, ХЗДХЯ-ны холбогдох журмын хоорондын давхардлыг арилгаж, нарийвчлан тусгах.	“Хойшлуулшгүй албан үүрэг гүйцэтгэх” гэдгийг тодорхойлж, бусад үед хэрэглэсэн бол хэрхэхийг журамд тусгаж өгөх.
14	<b>237. ГАЛТ ЗЭВСЭГ, ТУСГАЙ ХЭРЭГСЭЛ ХЭРЭГЛЭСЭН ТАЛААР ШАЛГАЛТ ЯВУУЛЖ, ДҮГНЭЛТ ХИЙХ</b>		

№	Журмын холбогдох заалт	Асуудал, дүгнэлт	Зөвлөмж
	237.2.4 Биеийн хүч, тусгай хэрэгслийг үндэслэлгүй, буруу хэрэглэсэн болон тусгай хэрэгслийг гээгдүүлж, үрэгдүүлсэн, бусдад шилжүүлсэн тохиолдолд, эсхүл тусгай хэрэгсэл хэрэглэсний улмаас бусдын амь нас хохирсон, бэртэж гэмтсэн, эд хөрөнгөд хохирол учруулсан тохиолдол бүрт албаны шалгалтыг явуулна.	Биеийн хүч хэрэглэхэд шалгалт явуулах эсэх, биеийн хүч, тусгай хэрэгслийг үндэслэлгүй буруу хэрэглэсэн үед шалгалт явуулах уу, эсхүл хэрэглэх бүрт шалгалт явуулах зэрэг нь тодорхойгүй байна. Учир нь зорилгын заалттай зөрчилдөж байна.	Журмын нэршилтэй таарахгүй байна.
15	<b>301. ГЭРЭЛ ЗУРАГ, ДУУ АВИА, ДҮРС БИЧЛЭГ ХИЙЖ АШИГЛАХ</b>		
	Гэмт хэргийг илрүүлэх, нотлох ажиллагаанд...	Уг журам нь “...гэрэл зураг, дуу авиа, дүрс бичлэг хийж ашиглах дэг горимыг тогтооход оршино” гэсэн зорилгоо хангаагүй байна.	Хэрхэн ашиглах загварчилсан зөвлөмж болгон өөрчлөх.
	301.4 Гэрэл зураг, дуу авиа, дүрс бичлэг хийх, ашиглах 304.4.1....	304.4.1 гэж буруу бичигдсэн байна.	304.4.1-ийг 301.4.1 гэж засах.
	301.4.3 Цагдаагийн алба хаагч эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны...	Байцаан шийтгэх ажиллагаа гэсэн үг байхгүй.	Өөрчлөх.

№	Журмын холбогдох заалт	Асуудал, дүгнэлт	Зөвлөмж
	301.4.5 Энэ ажиллагааг хийлгэхээр үүрэг, даалгавар өгсөн албан тушаалтан нь алба хаагчийн аюулгүй байдлыг хариуцна.	Хэт ерөнхий бичсэн байна.	Байдлыг гэсний дараа “хангуулан ажиллах бөгөөд үүрэг чиглэл тухай бүрт өгсөн байх” гэж илүү тодорхой үүрэгжүүлэх.
16	<b>303. БАНК, БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГААС МЭДЭЭЛЭЛ АВАХ</b>		
	303.4.5 ... ажилтанд мэдэгдэж, нууцыг задруулахгүй байж, нууцыг задруулахгүй байх үүргийг сануулж, бичгээр баталгаа гаргуулна.	“...нууцыг задруулахгүй байж, нууцыг задруулахгүй байх үүргийг сануулж, ...” гэсэн хэсэг өгүүлбэр зүйн алдаатай.	Давхардсан үгийг хасаж найруулах.
17	<b>304. ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ АВАХ, ТУСГАЙ ТЭМДЭГЛЭЛ ХИЙЛГЭХ</b>		
	“Зохион байгуулалттай гэмт бүлэг” - ... 3, түүнээс олон хүний тогтвортой нэгдлийг.	Хуульд нийцүүлэх.	2 ба түүнээс дээш гэж шинэчлэн оруулах.
18	<b>305. ГЭМТ БҮЛЭГЛЭЛИЙН ТАЛААР МЭДЭЭЛЛИЙН САН БҮРДҮҮЛЭХ, АШИГЛАХ</b>		
	305.4.2 Санд мэдээлэл оруулж, баяжилт хийхдээ дараах чиглэлийг баримтална:	Сүүлийн үед шинээр үйлдэгдэж буй цахим гэмт хэрэг нь зохион байгуулалттай, үргэлжилсэн үйлдэлтэй болж байна.	Цахим гэмт хэргийг нэмж оруулах.

№	Журмын холбогдох заалт	Асуудал, дүгнэлт	Зөвлөмж
19	<b>308. ХЯЛБАРШУУЛСАН ХЭРЭГ БҮРТГЭЛТ ЯВУУЛАХ</b>		
	308.1 Зорилго: Цагдаагийн байгууллагын мөрдөгчөөс ...	Зөрчлийн хэргийг хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэх ажиллагааг хэрхэн явуулах, анхаарах асуудал тусгагдаагүй байна.	Зөрчлийн хэргийг хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэх ажиллагааны талаар орхигдуулсан байгааг анхаарах.
	308.4 Хялбаршуулсан хэрэг бүртгэлт	ЭХХШТХ-ийн 17-р бүлгийг эшлэх.	Хуульд нийцүүлэн ЦАХ-ийн гүйцэтгэх үйл ажиллагааны дэс дарааллыг нарийвчлан тусгаж өгөх, практикт гаргаж буй нийтлэг алдаанаас зайлсхийхэд журам чиглэх ёстой.
308.3.2 Хялбаршуулсан хэрэг ...журмыг журмыг баримтална.	Үг давхардуулсан	“журмыг” гэсэн үг давхардсаныг хасах.	
20	<b>310. ТӨРИЙН ЗАРИМ АЛБАН ХААГЧИЙН ТАЛААР ЗААВАЛ МЭДЭГДЭХ</b>		
	310.2.1 Энэхүү журмыг дараах албан тушаалтнуудыг гэмт хэргийн газарт гэмт үйлдлийнх нь нотлох баримттайгаар ...	Утгын алдаатай. “... гэмт хэргийн газарт гэмт үйлдлийнх нь нотлох баримттайгаар барихаас бусад тохиолдолд ...” гэсэн нь “гэмт хэрэг үйлдсэн байж болох” гэсэн сэжгээр гэмт хэрэгт холбогдуулан шалгаж болох мэт ойлгогдож байна.	Найруулгыг засах.
	310.4.2, 4.3, 4.4	Зарим албан тушаалтныг хэрхэх нь тодорхойгүй, тухайлбал, ҮХЦ-ийн дарга	Орхигдсон албан тушаалтныг нэмж тусгах.



№	Журмын холбогдох заалт	Асуудал, дүгнэлт	Зөвлөмж
21	<b>313. ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТАЛААР ЭРХ ЗҮЙН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ</b>		
	313.4 ...	ЭХХШТХ-ийн заалтыг шууд давхардуулсан.	Давхардлыг арилгаж, эшлэн оруулах.
22	<b>320. ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫГ ГАРГУУЛАХ</b>		
	320.2.1 Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардлаас...	316.3.6... 4-өөс илүү цаг зарцуулахаар бол түүнийг хооллуулах арга хэмжээг авна гэсэн ч насанд хүрээгүй этгээдийг хооллох зардал тусгагдаагүй байна.	Уг зардлыг оруулах.
23	<b>325. ОЙ, ХЭЭРИЙН ТҮЙМРИЙН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ, ТҮҮНИЙГ ШАЛГАХ</b>		
	325.2.2 ... хойшлуулшгүй ажиллагааг явуулна.	“хойшлуулшгүй ажиллагаа” гэсэн нэршил байхгүй.	Хойшлуулшгүй ажиллагаа гэсэн нэршлийг өөрчлөх.
24	<b>400. ЦАГДААГИЙН ЭРГҮҮЛ, ХАРУУЛЫН ДҮРМИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ</b>		
	400.4.3 ... хойшлуулшгүй ажиллагаа явуулна.	“хойшлуулшгүй ажиллагаа” гэсэн нэршил байхгүй.	Хойшлуулшгүй ажиллагаа гэсэн нэршлийг өөрчлөх.
25	<b>401. ЭРГҮҮЛИЙН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭХ</b>		
	401.3.6 Эргүүл, харуулын дүрэмд хориглосон аргаар эргүүлийг шалгаж болохгүй.	Эргүүлийн харуулын дүрмийг хэн, хаанаас баталсныг дурдах.	Тодорхой заах.
	401.4.1 д/ хуульд заасан хойшлуулшгүй ажиллагаа явуулах;	“хойшлуулшгүй ажиллагаа” гэсэн нэршил байхгүй.	Өөрчлөх.

№	Журмын холбогдох заалт	Асуудал, дүгнэлт	Зөвлөмж
	401.4.2 ...шаардлагатай гэж үзвэл камерыг асааж бичлэг хийнэ.	Шаардлагатай гэж ямар тохиолдлыг ойлгох вэ? Шаардлагагүй гэж үздэг гэтэл амьдрал дээр цагдаагийн алба хаагч буруудах үндэслэл болох.	Тодорхой зааж өгөх.
26	<b>402. АВТО ЭРГҮҮЛ АЖИЛЛАХ</b>		
	402.5.3 ... зогсож, хяналт тавих цэгүүдийг тогтоон өгч зогсох, тойрох цагийг нарийвчлан зааж өгч хяналт тавиулж болно.	Зогсох гэдэг нь давтагдсан.	Найруулгыг засах.
	402.5.5 Ажил хүлээлцэхдээ ахлах болон эргүүлийн офицер ...	Тогтсон нэршил хэрэглээгүй.	Ажлын байрны нэр томъёоны нэршлээр хэрэглэх.
	402.6.6 ... хойшлуулшгүй ажиллагаа явуулж эхэлнэ.	“хойшлуулшгүй ажиллагаа” гэсэн нэршил байхгүй.	Хойшлуулшгүй ажиллагаа гэсэн нэршлийг өөрчлөх.
	402.6.11 ...боломжтой хэмжээгээр эрэн сурвалжилж, сэжигтэй хүн, эд зүйлийг шалгаж, энэ тухай тэмдэглэл үйлдэн төвд мэдээлнэ.	“Боломжтой” гэсэн нэршил нь ойлгомжгүй байна.	Тодотгох.

№	Журмын холбогдох заалт	Асуудал, дүгнэлт	Зөвлөмж
	402.6.13 Тусгай дуут болон гэрлэн дохиогоо ажиллуулан замын хөдөлгөөнд оролцож байгаа үед замын хөдөлгөөний дүрмийн дагуу тухайн алба хаагч өөрийн болон бусдын аюулгүй байдлыг хангаж явах үүрэгтэй.	Нөхцөл байдлыг хяналтад авч явахыг үүрэг болгосон нь бодит байдалд хэрэгжихэд хүндрэл дагуулж болзошгүй.	Практикт Тээврийн цагдаагийн албанд УБ бүсийн эргүүл нь “цагдаа жолооч”-гүй үүрэг гүйцэтгэж байна. Энэ тухайгаа ... мэдэгдэнэ, ганцаар үүрэг гүйцэтгэж байгаа тохиолдолд ... арга хэмжээ авна гэж тодорхой зааж өгөх.
	402.6.14 “Яаралтай” дуудлагын дагуу ажиллахдаа нөхцөл байдлаас хамаарч...	Нөхцөл байдлаас хамаарч гэсэн нь ойлгомжгүй, тодорхойгүй нөхцөл байдлыг үүсгэж байна.	Нөхцөл байдал гэдэгт ямар утга илрэх талаар тусгаж заах.
27	<b>404. НИЙТИЙН БОЛОН ХЭВ ЖУРМЫН УРАМШИЛТАЙ ЭРГҮҮЛ, ЖИЖҮҮРИЙГ МЭРГЭЖЛИЙН УДИРДЛАГААР ХАНГАЖ, ХАМТРАН АЖИЛЛАХ</b>		
	404.6.3 ...эргүүл, жижүүрийг хуульд зааснаар шагнаж урамшуулна.	Тодорхой болгох.	Ямар хуулийн дагуу шагнах тэр талаар эш татан заах.
28	<b>405. СААТУУЛСАН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ ХАДГАЛАХ</b>		
	Монгол Улсын хууль зүйн сайдын 2015 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн А/190 дугаар тушаалаар баталсан журмаар зохицуулагдана.	2016 оны 07 сарын 01-ны өдрийн А/209 дүгээр тушаалаар өөрчлөлт орсон.	Шинэчлэх.

№	Журмын холбогдох заалт	Асуудал, дүгнэлт	Зөвлөмж
	405.5.3 Мөрдөгч нь битүүмжилсэн тээврийн хэрэгслийг хүлээлгэж өгөхдөө хүлээлцэх тэмдэглэл бичиж, тэмдэглэлийн дагуу өөрийн биеэр харуулд хүлээлгэн өгч гарын үсэг зуруулна.	ЦБУАЖ 405.5.2-т тээврийн хэрэгслийг хүргэж ирсэн алба хаагч нь ... гэсэн боловч 405.5.3-т мөрдөгч гэсэн нь ойлгомжгүй байна. Мөрдөгчөөс бусад нь тэмдэглэл бичихгүй байхаар ойлгогдож байна.	405.5.3. Алба хаагч нь битүүмжилсэн тээврийн хэрэгслийг хүлээлгэж өгөхдөө хүлээлцэх тэмдэглэл бичиж, тэмдэглэлийн дагуу өөрийн биеэр харуулд хүлээлгэн өгч гарын үсэг зуруулна гэж өөрчлөх.
29	<b>406. ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙГ ЗОХИЦУУЛАХ, ХЯНАЖ ШАЛГАХ</b>		
	Хууль зүйн сайдын 2015 оны А/190 дүгээр тушаалаар баталсан Замын хөдөлгөөн зохицуулах, хянан шалгах журмаар зохицуулна.	2016 оны 07 сарын 01-ний өдрийн А/209 дүгээр тушаалаар өөрчлөлт орсон.	Өөрчлөх.
	Замын хөдөлгөөн зохицуулах, хянан шалгах журмын 3.2-т ... 3.2.4. шаардлагатай үед зохицуулдаггүй уулзвар, гарц дээр...	Амьдралд цагдаагийн алба хаагч зохицуулдаг уулзвар дээр биечлэн зохицуулалт хийж байна. Тиймээс биечлэн зохицуулалт хийж байгаад эрүүл мэнд, амь насаараа хохирсон тохиолдолд хэн буруудах вэ гэсэн асуулт гарч байна.	“Шаардлагатай үед” гэдгийг тодорхой зохицуулах ёстой, үгүй бол зохицуулагч өөрийн үзэмжээр зохицуулалт хийх боломжтой байгаа нь оновчтой биш.
	Журамд тусаагүй.	Зохицуулалттай уулзвар дээр зохицуулалт хийх асуудлыг нарийвчлан заах шаардлагатай.	Зохицуулдаг уулзвар дээр биечлэн зохицуулалт хийх асуудлыг журамлах.

№	Журмын холбогдох заалт	Асуудал, дүгнэлт	Зөвлөмж
30	<b>407. ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙГ ЗӨӨВӨРЛӨН ШИЛЖҮҮЛЭХ</b>		
	Хууль зүйн сайдын 2015 оны А/190 дүгээр тушаалаар баталсан “Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах журам”-аар зохицуулна.	2016 оны 07 сарын 01-ний өдрийн А/209 дүгээр тушаалаар өөрчлөлт орсон.	Өөрчлөх.
31	<b>409. ХЭРЭГ БҮРТГЭХ АЛБА, ТАСАГ НЭГЖИЙН ДАРГА, АХЛАХ НАРААС ЗӨРЧЛИЙН ХЭРЭГ БОЛОН ЗӨРЧЛИЙН ТАЛААРХ ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛД ХЯНАЛТ ТАВИХ</b>		
	409.1 Зорилго ...	2018 оны 12 дугаар сарын 24-ний өдөр шинэчлэн батлагдсан.	Өөрчлөх.
	409.2 Хамрах хүрээ ...	ЗШШТХ-д зааснаар “зөрчлийн хэрэг бүртгэлтийг удирдах албан тушаалтан” гэсэн нэр томъёог хэрэглэж байна. Тиймээс журмын нэрийг хуульд нийцүүлэн өөрчлөх.	Зөрчлийн хэрэг болон зөрчлийн талаарх гомдол мэдээлэлд хяналт тавих.
32	<b>500. НИЙТИЙН ХЭВ ЖУРАМ ХАМГААЛАХ, ОЛОН НИЙТИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ</b>		
	500.4.2 Цагдаагийн эргүүл, харуулын үйл ажиллагаанд ...захиргааны зөрчлийг ...	“Цагдаагийн эргүүл, харуулын дүрэм”-ийг цагдаагийн төв байгууллагаас батлаагүй. Засгийн газрын 1994 оны 106 дугаар тогтоолын 1-р хавсралтаар баталсан “Цагдаагийн эргүүл, харуулын дүрэм”-ийг баримтлах эсэхэд ойлгомжгүй байдлыг үүсгэж байна. Захиргааны зөрчил гэсэн нэр томъёог хуульд нийцүүлэх.	Засах.

№	Журмын холбогдох заалт	Асуудал, дүгнэлт	Зөвлөмж
	500.6.5 Олон нийтийн арга хэмжээ ..., 500.21. нийтийг хамарсан арга хэмжээ ...	Нэг агуулгыг 2 янзаар нэрлээд байна.	Засах.
33	<b>501. ДИПЛОМАТ ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗАР, УЛСЫН ОНЦ ЧУХАЛ ОБЪЕКТЫН ХАРУУЛ, ХАМГААЛАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ</b>		
	501.2.4 Дипломат төлөөлөгчийн газар, ... хяналт тавьж ажиллана.	Энэ өгүүлбэр эзэн биегүй байна.	Засах.
	501.5.2 ... г/алба хаагчдаар бүх төрлийн аюулгүйн арга хэмжээг сахиулах	Алба хаагчдаар бүх төрлийн аюулгүй арга хэмжээг сахиулна гэж заасан нь хуульд нийцэх эсэх.	Зааварчилсан заалт нэмэх.
	501.5.10 Харуулын цагдаа нь дараах үүрэгтэй: и/“Гэмт хэрэг, зөрчлийг шалгах хойшлуулшгүй ажиллагаа	Хойшлуулшгүй ажиллагаа гэж хуульд заагаагүй байна.	Өөрчлөх.
34	<b>502. ЖАГСААЛ, ЦУГЛААНЫ ҮЕД ОЛОН НИЙТИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ</b>		
	502.2 Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно: “Цуглаан” – ... “Жагсаал” – ...	Хуульд заасан нэр томъёог эш татсан байдлаар бус эх сурвалжийг дурдах байдлаар журамд хэрэглэх.	Хуулийн холбогдох зүйл, заалтыг эш татах.

№	Журмын холбогдох заалт	Асуудал, дүгнэлт	Зөвлөмж
35	<b>508. ГАМШГИЙН ҮЕИЙН ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА</b>		
		Хуульд заасан “гамшиг”, “аюулт үзэгдэл” гэсэн нэр томъёог дахин тайлбарлах шаардлагагүй.	Хуулийн зүйл, заалтыг эш татсан байдлаар хэрэглэх.
36	<b>510. ЗАРИМ ОБЪЕКТЫГ ХАМГААЛАХ, ТҮР ХАМГААЛАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ</b>		
	510.1 Зорилго: Шаардлагатай үед ..	“Шаардлагатай үед”, “зарим” гэдэгт ямар утга санаа илэрхийлэгдэж байгааг тодотгох.	ЗГ-ын ... баталсан .... жагсаалтад багтсан гэж объектуудыг тодорхой заах.
	510.2.1 Цагдаагийн албаны тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын тогтоол, цагдаагийн төв байгууллагын даргын шийдвэрээр зарим объект ...		
37	<b>512. УЛСЫН ОНЦ ЧУХАЛ ОБЪЕКТОД ГАДААДЫН ИРГЭН НЭВТРҮҮЛЭХ, ХЯНАЛТ ТАВИХ, ХАМТРАН АЖИЛЛАХ</b>		
	512.2.2 Улсын онц чухал объектын ...	Өгүүлбэр, найруулгын хувьд ойлгомжгүй байна.	Засах.
	512.3 Нэр томъёо: “Гадаадын иргэн” - Монгол Улсын иргэний харьяалалгүй бөгөөд гадаад улсын иргэний харьяалалтай хүнийг	Хуулийн нэр томъёог шууд хэрэглэсэн байна.	Эш татаж зааж өгөх.

№	Журмын холбогдох заалт	Асуудал, дүгнэлт	Зөвлөмж
38	<b>601. ХОРИХ ЯЛ ЭДЛЭЭД СУЛЛАГДСАН ЗАРИМ ХҮНД ЗАХИРГААНЫ ХЯНАЛТ ТОГТООХ</b>		
	601.2.4 Гэмт хэргээс урьдчилан...	Хуулийн зүйл заалтыг хуулбарлах биш, эшлэх.	
39	<b>602. ГАЛТ ЗЭВСГИЙГ БҮРТГЭХ, ГЭРЧИЛГЭЭ ОЛГОХ</b>		
			Хуулийг хуулбарлан давтахгүй, харин эшлэх
40	<b>605. ГЭРЭЭТ ХАРУУЛ ХАМГААЛАЛТ, ХУВИЙН ХАМГААЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ГЭРЧИЛГЭЭ ОЛГОХ, ХЯНАЛТ ТАВИХ</b>		
	Журам 605.1. Гэрээт харуул хамгаалалт, хувийн хамгаалалт эрхлэх хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээдийг бүртгэх, зөвшөөрөл олгох, хяналт тавих харилцааг зохицуулахад оршино.	Гэрээт харуул, хамгаалалтын тухай хуулийн 7.4-өөр тус журмыг дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална гэсэн ч ЦБҮАЖ код 605 ЦЕГ-ын даргын тушаалаар батлагдсан байгаа нь хууль зүйн үндэслэлгүй байна.	Журмын нэрийг өөрчлөх, зохицуулах харилцааг нь өөрөөр томъёолох.
41	<b>606. ТЭСЭРЧ ДЭЛБЭРЭХ БОДИС, ТЭСЭЛГЭЭНИЙ ХЭРЭГСЛИЙН ЭРГЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ</b>		
	606.1 ... санал өгөх горимыг тогтооход оршино.	Журамд хэдэн хоногт энэхүү үйл ажиллагааг хэрэгжүүлэхийг заагаагүй байна.	Санал өгөх процессын хугацааг зааж өгөх.
42	<b>612. ТӨМӨР ЗАМЫН ГАРМЫН ЗЭРЭГЛЭЛ ТОГТООХОД САНАЛ ӨГӨХ</b>		
	612.1 Зорилго: Төмөр замын гармыг нээх, хаах, ашиглах ...	Хэнд санал өгөх нь тодорхойгүй байна.	Тодотгох.



№	Журмын холбогдох заалт	Асуудал, дүгнэлт	Зөвлөмж
43	<p><b>616. УЛСЫН БОЛОН ИРГЭНИЙ АГААРЫН ХӨЛГИЙГ ЭРЭН ХАЙХ, АВРАХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОХ</b></p> <p>в/цагдаагийн алба хаагч нь осолдсон, олдсон, агаарын хөлгийн талаарх мэдээллийг зохих байгууллагад нэн даруй мэдэгдэж ...</p>	<p>Зохих байгууллагад нэн даруй мэдэгдэх гэж заасан ч яг хэнд мэдэгдэх нь тодорхойгүй байна.</p>	<p>Тодорхой зааж өгөх.</p>
44	<p><b>617. ОЛДВОР, ГЭЭГДЭЛ ЭД ХӨРӨНГӨ, АЛДУУЛ МАЛЫГ БҮРТГЭХ, ЛАВЛАГАА ГАРГАХ</b></p> <p>617.5 Бусад зүйл ... б/хар тамхи, мансууруулах бодисыг гээгдэл эд хөрөнгө гэж үзэхгүй.</p>	<p>Хар тамхи, мансууруулах бодисыг хэрхэн шийдвэрлэх тухай тусгаагүй. Мөн галт зэвсгийг гээгдэл эд хөрөнгө гэж үзэх үү?</p>	<p>Хар тамхи, мансууруулах бодис, галт зэвсэг гэж нэмж оруулах шаардлагатай.</p>
45	<p><b>619. ТЭНСЭГДСЭН, ХУУЛЬ ЗӨРЧСӨН ХҮҮХДЭД ХЯНАЛТ ТАВИХ</b></p> <p>619.1 Зорилго Цагдаагийн байгууллагын захиргааны үүргийн хүрээнд шүүхийн зарим шийдвэрийг гүйцэтгэх хэм хэмжээг тогтооно.</p>	<p>Хуульд нийцүүлэн нэр томъёог хэрэглэх шаардлагатай.</p>	<p>Тэнсэгдсэн, хууль зөрчсөн гэдэг үгийн агуулгыг тодотгох, хуульд нийцүүлэн өөрчлөх, ингэхдээ ЦБ-аас Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан чиг үүргийнхээ хүрээнд ял хойшлогдсон, ял тэнссэн насанд хүрээгүй хүмүүсийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах үүрэгтэйг анхаарах.</p>

№	Журмын холбогдох заалт	Асуудал, дүгнэлт	Зөвлөмж
	619.3 б/... захиргааны шийтгэл хүлээсэн бол...	Захиргааны шийтгэл гэсэн нэр томьёо хэрэглэгдсэн байна. Шүүхэд хэрхэн санал гаргах процедурыг тодотгох.	Тодотгох.
46	<b>620. ЗАРИМ АЛБАН ТУШААЛТАН, ТЭДГЭЭРИЙН ГЭР БҮЛИЙГ ХАМГААЛАХ</b>		
	в/ Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.4-т заасныг үндэслэн... хамгаалалтад авч болно.	Журамд зааснаас өөр бусад хамаарал бүхий этгээд өртөх тохиолдол гардаг.	Гэр бүлийн гишүүд, хамаарал бүхий этгээдүүдийг нэмж оруулах.
47	<b>621. АЛБАДАН ЭМЧИЛГЭЭНД ЯВУУЛАХ</b>		
	Журам 621.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба хуяглан тухайн этгээдийг саатуулах, шүүхийн шийдвэр гарсны дараа албадан эмчлэх газарт хүргэх ажиллагааг зохион байгуулан явуулж байна.	Энэ заалтыг хасах.
48	<b>622. АЛБАДАН СААТУУЛАХ</b>		
	Журам бүхэлдээ	“Захиргааны журмаар албадан саатуулах байрны дэглэм, журам гэдэг нэр томьёо хэрэглэхгүй байгаа.	“Захиргааны журмаар албадан саатуулах байрны дэглэм, журмыг өөрчилж албадан саатуулах болгож хооронд нь уялдуулах.

№	Журмын холбогдох заалт	Асуудал, дүгнэлт	Зөвлөмж
49	624. ИРГЭНИЙ ХАРЬААЛЛЫН АСУУДЛААР САН БҮРДҮҮЛЭХ, ЛАВЛАГАА ӨГӨХ		
50	628. ГАЛТ ЗЭВСЭГ, СУМ АШИГЛАН СПОРТ-СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ, ХЯНАЛТ ТАВИХ		
51	629. АЛБАДАН ЭРҮҮЛЖҮҮЛЭХ		
	629.6.1 Эрүүджүүлэх байрны ажилтны дэг журмыг хангах чиглэлээр дараах үүрэгтэй: ... и/олон хоногоор ...	Олон хоногоор уусан эсэхийг хэрхэн тогтоох.	Тодорхой болгох.

## 3.4. Үйлчлэл нь дотогшоо чиглэсэн журмууд

Хүснэгт 6.

№	Журмын холбогдох заалт	Асуудал, дүгнэлт	Зөвлөмж
1	<b>212. БИЕЧИЛСЭН СУДАЛГАА ХИЙХ</b>		
2	<b>235. ГАЛТ ЗЭВСЭГ ХАДГАЛАХ, ХАМГААЛАХ, БҮРТГЭХ, ТАВЬЖ ОЛГОХ, БУУДЛАГА ХИЙХ</b>		
3	<b>236. ТУСГАЙ ХЭРЭГСЛИЙГ ХАДГАЛАХ, ХАМГААЛАХ, БҮРТГЭХ, ТАВЬЖ ОЛГОХ</b>		
	Практикт чанарын шаардлага хангахгүй тусгай хэрэгсэл тавьж олгох асуудал байдаг тул энэ асуудлыг журмаар нарийвчлан зохицуулах.		
	<b>239. АЖЛЫН БАЙРНЫ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ</b>		
4	239.5.2 Ажлын байрны сургалтын хөтөлбөрийн загварыг Цагдаагийн төв байгууллагын Хүний нөөц, сургалтын ажил хариуцсан нэгж, цагдаа, дотоодын цэргийн сургалтын ажил хариуцсан нэгжтэй хамтран боловсруулна.	Сургалтын хөтөлбөрийн загварыг хавсаргах шаардлагатай. Уг хөтөлбөрт шинээр томилогдсон, өөр ажилд шилжсэн алба хаагчаас гадна албан тушаал ахихын өмнөх сургалтад хамрагдах асуудал тусгагдаагүй. Энэ нь хүний эрхийн зөрчлийг гаргуулахгүй байх, алба хаагчдын хүний эрхийн сэтгэлгээг хөгжүүлэх, албаны нэр хүндийг дээшлүүлэхэд тустай.	ЦАХ ажилд орохоос эхлэн тодорхой давтамж, үе шаттайгаар хүний эрхийн сургалтад хамрагдахыг журамлах; уг ажлын байрны сургалтын хөтөлбөрийн агуулгыг тусгах; агуулгад хүний эрхийн сэдэв, хичээлийн хөтөлбөрийг оруулах, сургагч-багш бэлтгэх. ЦБҮАЖ код 951.3-т “Алба хаагчийн үргэлжилсэн сургалтын чиглэл, багтаамж” гэсэн заалтын хүрээнд “Хүний эрхийн сургалт”-ыг нэмэх, уг сургалтад алба хаагч бүр заавал хамрагдахыг журамлах.
5	<b>241. ТУСГАЙ БҮЛГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА</b>		
6	<b>243. ОЛОН НИЙТИЙН ЦАГДААГ АЖИЛЛУУЛАХ</b>		
7	<b>244. ЦАГДААГИЙН АЛБАНЫ АВТОМАШИНТАЙ ХОЛБООТОЙ ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛЫГ БҮРТГЭХ</b>		

№	Журмын холбогдох заалт	Асуудал, дүгнэлт	Зөвлөмж
8	245. ТЭМДЭГЛЭЛ, ИЛТГЭХ ХУУДАС ҮЙЛДЭХ		
9	300. ГЭМТ ХЭРЭГ ИЛРҮҮЛЭХЭД ОРЧИН ҮЕИЙН ТЕХНИК, ТЕХНОЛОГИ, МЭДЭЭЛЛИЙН СҮЛЖЭЭНИЙ ОЛОЛТЫГ АШИГЛАХ		
	300.4.1 Шинжлэх ухааны үндэслэлтэй арга тактик, техник хэрэгслийг аргачилсан заавар, зөвлөмж, удирдамжийн үндсэн дээр ашиглана...	Журмын 300.2.1-ийн б/ хэсэгт ... хууль ёсны ашиг сонирхол, эрх эрх чөлөөг хамгаалахад чиглэгдсэн байх гэж нэмж өгөх нь зүйтэй юм.	Аргачилсан заавар зөвлөмж, удирдамж боловсруулах шаардлага тулгарч байна.
10	306. МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГААНЫ МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛ, ТҮҮНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ		
11	307. ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ ЯВУУЛАХ		
12	513. ХАРУУЛЫН ЗААВАР БОЛОВСРУУЛАХ, МӨРДӨЖ АЖИЛЛАХ		
13	514. НУУЦ ҮГ, БАТЛАХ ДУГААРААР ХАРЬЦАХ		
14	515. ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОХ		
	НҮБ-ын дүрэм, олон улсын гэрээ, тухайн ажиллагааны удирдлагаас тогтоосон дүрэм, журам, бүс нутгийн байгууллага, тухайн ажиллагаа явагдаж байгаа улстай байгуулсан гэрээ, хэм хэмжээг тодорхой зааж өгөх.		

## ДҮГНЭЛТ

“Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам хүний эрхэд нийцсэн байдал” сэдэвт судалгааны хүрээнд 132 журмыг сонгон авч судалж үзсэний дүнд дараах дүгнэлтийг хийж байна.

1. Монгол Улсын цагдаагийн байгууллага 2008 оноос үйл ажиллагаагаа зохицуулсан дотогш чиглэсэн эрх зүйн актуудыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэн системчлэх ажлыг эхлүүлсэн билээ. Үйл ажиллагааны журмуудыг кодчилж, 2011, 2013, 2018 онуудад ном хэлбэрээр, өдгөө 4 дэх эмхэтгэл нь хэвлэгджээ. Мөн нэгж журам шинэчлэгдэх бүрт нэгжүүдэд цагдаагийн байгууллагын дотоод сүлжээгээр цахим хэлбэрээр хүргүүлж, цаг алдалгүй ашиглах боломжийг хангаж иржээ.
2. Энэ хугацаанд Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Цагдаагийн албаны тухай хууль шинээр батлагдсантай холбогдуулан зохих өөрчлөлтийг тухай бүрд нь хийсэн байна.
3. Бидний сонгосон 132 журмаас хүний эрхийг хамгаалахаар тухайлан боловсруулсан 3, хүний эрхийг тухайлан заасан 46 журам байна. Эдгээр журам нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд явуулахдаа хүний эрхийг хамгаалж ажиллахтай холбоотой зохицуулалт юм.
4. Цагдаагийн байгууллагын эрх хэмжээ нь хүний эрхэд суурилж, түүгээр хязгаарлагдаж байх ёстой. Дүн шинжилгээ хийсэн 132 журмаас 45-д нь цагдаагийн байгууллага, алба хаагчаас гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны үед хүний эрхийг хамгаалж ажиллах зохицуулалтууд зохих ёсоор тусгагджээ. Үүнээс 14 журмын үйлчлэл дотогшоо чиглэсэн хэдий ч цагдаагийн алба хаагч үйл ажиллагаагаа хүний эрхэд нийцүүлэн явуулахад тодорхой хэмжээнд нөлөөлөх тул шинжилгээнд хамруулсан болно.
5. Хууль тогтоомж, хүний эрхийн хэм хэмжээнд бүрэн нийцүүлэх үүднээс нэмэлт, өөрчлөлт оруулах, шинээр боловсруулах

шаардлагатай 87 журам байна. Нийтлэг зөрчил нь хууль тогтоомжид байхгүй нэр томъёог хэрэглэсэн, эсхүл хууль тогтоомжийг хуулбарлан давтах явдал илүүтэй харагдлаа. Мөн журмын зорилгоо бүрэн хангаагүй буюу цагдаагийн алба хаагч гэмт хэрэгтэй тэмцэх, хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг сахин хамгаалахад зайлшгүй шаардлагатай үйл ажиллагааны дэс дарааллыг журамлаагүй, хэт ерөнхий байдлаар боловсруулсан журмууд байна.

6. ЦБҮАЖ нь алба хаагчийн дур зоргоор авирлахыг таслан зогсоох, хүний эрхийг зөрчихөөс сэргийлэх, байгууллагын цэгцтэй, үр ашигтай үйл ажиллагааг дэмжих, хариуцан тайлагнах тогтолцооны үндсийг тавихын зэрэгцээ зохицуулалтын шийдвэрийн талаар маргаан гарсан тохиолдолд байгууллагын байр суурийг хамгаалах зорилготой, зайлшгүй мөрдөх алхмуудыг илэрхийлсэн байв. Тиймээс эдгээр 87 журмыг холбогдох хууль тогтоомжийн дагуу засаж, сайжруулах шаардлага байгаа нь тодорхойлогдлоо.
7. ЦБҮАЖ нь холбогдох олон улсын гэрээ, конвенц<sup>14</sup>, хууль тогтоомжийн дагуу боловсруулагдсан, хууль тогтоомж шинэчлэгдэх бүрт тэдгээрт нийцүүлэн нэмэлт өөрчлөлт оруулж ирсэн хэдий ч цаашид хүний эрхийг хангах чиглэлээрх олон улсын баримт бичиг, стандартуудад нийцүүлэн улам боловсронгуй болгох шаардлагатай. Үүний тулд алба хаагчийн үйл ажиллагаа, хийх ажлын дэс дарааллыг нарийвчилсан буюу тодорхой алхамтай, аргачилсан заавруудыг боловсруулах, холбогдох хуулийн зүйл, заалт, нэр томъёог дахин тайлбарласан, давхардуулсан заалт бүхий хэсгүүдийг засан сайжруулах, найруулга зүйн хувьд ойлгомжгүй заалтын агуулгыг шинэчлэх хэрэгтэй байна.
8. Түүнчлэн тодорхой ажиллагааны үед цагдаагийн алба хаагч өөрийн аюулгүй байдлыг ханган ажиллах, эрх нь зөрчигдсөн тохиолдолд хэрхэх (ялангуяа ганцаар ажиллаж байгаа, алслагдмал

<sup>14</sup> НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1979 оны 34/169 тогтоолоор баталсан “Хууль хэрэгжүүлэх албан тушаалтнуудын зан үйлийн тухай хууль”, НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн зөвлөлийн 1989 оны 1989/61 дугаар тогтоолоор баталсан “Нийгмийн хэв журам сахиулах үүрэг бүхий албан тушаалтнаас хүч хэрэглэх болон галт зэвсэг хэрэглэх үндсэн зарчим”, Европын Зөвлөлийн Сайд нарын Зөвлөлөөс гаргасан “Цагдаагийн ёс зүйн тухай Европын хэм хэмжээний талаарх зөвлөмж”, НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссаруудын газраас гаргасан “Цагдаагийн албан хаагчийн үйл ажиллагаанд баримтлах олон улсын хүний эрхийн стандарт”, “НҮБ-ын цагдаагийн хууль сахиулах үйл ажиллагааны стандарт” зэрэг.

газарт байх үед гэх мэт) талаарх зохицуулалтууд хомс байх тул тэдгээрийг журамласан, хариуцсан дарга нарт үүрэг болгосон зохицуулалтуудыг бий болгох нь зүйтэй.

9. ЦБҮАЖ нь эрх зүйн эх сурвалжийн хувьд захиргааны хэм хэмжээний акт мөн эсэх нь онолын хувьд судлаачдын дунд маргаантай байдаг бөгөөд энэ талаар тухайлан судлах нь журмын цаашдын шинэчлэлд чухал ач холбогдолтой юм.



## САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Энэхүү судалгааны ажлын хүрээнд дараах санал, зөвлөмжийг дэвшүүлж байна. Үүнд:

1. Цагдаагийн төв байгууллагаас өөрийн үйл ажиллагаандаа зориулсан “хүний эрхийн стандартыг хэрэгжүүлэх цогц бодлого”-ыг батлах, энэхүү бодлогыг хэрэгжүүлэх талаар ЦБҮАЖ-д тусгаж өгөх.
2. Цагдаагийн алба хаагчид нь олон улсын хүний эрхийн стандартуудыг сайтар мэдэх, хэрэглэх үүрэгтэй. Цагдаагийн байгууллагад хүний эрхийн зөрчлийг гаргуулахгүй байх, алба хаагчдын хүний эрхийн сэтгэлгээг хөгжүүлэх, албаны нэр хүндийг дээшлүүлэхийн тулд цагдаагийн алба хаагч анх ажилд орохоос эхлэн давтамжтайгаар хүний эрхийн сургалтад заавал хамруулах талаар журамд тусгах. Тухайлбал, ЦБҮАЖ код 951.3-т “Алба хаагчийн үргэлжилсэн сургалтын чиглэл, багтаамж” гэсэн заалтын хүрээнд “Хүний эрхийн сургалт”-ын талаар гэж тодотгон зааж өгөх, хүний эрхийн сургалтад алба хаагч бүр заавал хамрагдах талаар тусгах; “Хүний эрхэд суурилсан хууль сахиулах ажиллагаа” сэдэвт сургалтын хөтөлбөр боловсруулж, сургагч-багш бэлтгэн алба хаагчдад сургалт зохион байгуулах.
3. Зарим тодорхой үйл ажиллагааны үед цагдаагийн алба хаагч хүний эрхийг хангаж ажиллах тухайлан зориулсан зөвлөмжийг журамд тусгаж өгөх. Үүнд: Ялгаварлан гадуурхахгүй, тэгш байх, мөрдөн шалгах, баривчлах, хүч болон галт зэвсэг хэрэглэх, эмх замбараагүй байдал, онц байдал, зэвсэгт мөргөлдөөн, насанд хүрээгүй хүнийг хамгаалах, эмэгтэйчүүд, хүүхдийн эрхийг хангах гэх мэт.
4. ЦБҮАЖ боловсруулах (нэмэлт, өөрчлөлт оруулах, шинээр журам гаргах, хүчингүй болгох, найруулга зүйг засварлах) ажилд цагдаагийн байгууллага, алба хаагчдаас тоймтой санал гаргахгүй байх, бусад мэргэжлийн хүмүүсийн саналыг авах, судалгаа дүгнэлт гарган ашиглах ажил дутмаг зэргээс ЦЕГ-ын Хуулийн хэлтэс, алба хаагчид голлон ажиллаж байгааг анхаарч, шинжлэх ухаанч байр

- сууринаас хандаж, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмыг боловсруулах ажилд холбогдох талуудын оролцоог хангах, шийдвэрийн нөлөөллийг урьдчилан судлах, үүнд хүний эрхийн шалгуур үзүүлэлтийг тусгайлан тусгаж өгөх нь зүйтэй.
5. ЦБҮАЖ-д засаж сайжруулах саналыг судалгааны тайланд тусгаж оруулсныг өмнөх хүснэгтүүдээс дэлгэрүүлэн харна уу.
  6. Цаашид эдгээр журмыг боловсронгуй болгох хүрээнд Олон улсын цагдаагийн дарга нарын холбооноос гаргасан жишиг код, бодлого болон хүний эрхийн билл, холбогдох бусад олон улсын гэрээ, хэм хэмжээг тусгайлан судлах шаардлагатай.